

НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАРТ ЗАСАГЛАЛЫН ТӨЛӨВ БАЙДЛЫН
ДОТООД ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2025 оны 04 дүгээр сарын 24

Багахангай дүүрэг

- Тус үнэлгээний ажлыг зохион байгуулахдаа дараах дотоод судалгаа, холбогдох дүрэм журмын хэрэгжилтийн байдал зэрэг мэдээлэлд тулгуурлан үнэллээ.
- Үүнд:
- Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр;
- Засаг даргын Тамгын газрын 2023-2024 оны стратеги төлөвлөгөө;
- Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлт;
- Байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ;
- Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөр, хэрэгжилт;
- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн журам;
- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээ;
- Иргэдээс ирүүлсэн сэтгэл ханамжийн судалгаа;

ЗОРИЛГО, АЛСЫН ХАРАА

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын зорилго, алсын хараа нь тэдний үйл ажиллагааны үндсэн чиглэл, ирээдүйн төлөв байдлыг тодорхойлдог. Зорилго нь байгууллагын хүрэхийг хүсэж буй үр дүнг, харин алсын хараа нь ирээдүйд ямар байхыг дүрслэн харуулдаг.

Асуулт-1

Зорилго, алсын хараа, стратегийг нийгэмд үйлчлэх, олон нийтийн хэрэгцээг хангах, иргэдийн амьдралыг сайжруулахад бүрэн чиглүүлэн ажилладаг.

Хариулт:

Зорилго, алсын харааг ажилтнуудтай уялдуулж, байгууллагын дотоодод ерөнхийдөө ойлгогдсон. Энэ нь байгууллагын хөгжлийн стратегийг боловсруулах, тактик, үйлдлүүдийг тодорхойлох боломжийг бүрдүүлдэг. Гэвч стратеги, зорилгыг дахин тодорхойлох үйл явцад байгууллага дурамжхан хандаж, өөрчлөлтийг хүлээн авах хандлага сул байна.

Баримтжуулалт:

Оюунбаатар

Асуулт-2

Зорилго, алсын хараа, стратегийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид бүрэн нийцүүлэн, хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа хариуцлагатайгаар явуулдаг.

Хариулт:

Байгууллагын зорилго, алсын харааг тодорхойлохдоо хууль эрх зүйн хүрээг харгалзан үзэж, ажилтнууд хууль эрх зүйн хүрээнд үйл ажиллагаа явуулах шаардлагатайг ойлгодог. Хууль эрх зүйн нийцтэй байдлыг хангах үндсэн журам, зааварчилгаа боловсруулагдсан байна.

Баримтжуулалт:

Цэнгэл эгч

Асуулт-3

Зорилго, алсын хараа, стратегийг дээд шатны байгууллагын стратеги, бодлоготой бүрэн уялдуулан, өөрчлөгдөж буй гадаад орчин, нийгмийн хэрэгцээнд цаг тухайд нь дасан зохицон ажилладаг.

Хариулт:

Зорилго, алсын харааг ажилтнуудтай харилцан тохиролцож, байгууллагын дотоодод ойлгогдсон. Стратеги боловсруулж, тактик, үйл ажиллагааг тодорхойлсон. Дээд шатны байгууллагын бодлоготой уялдуулах ажил хийгдсэн. Гадаад орчны өөрчлөлтөд дасан зохицох боломжийг хүлээн зөвшөөрдөг боловч өөрчлөлт хийх үйл явц хойрго байна.

Баримтжуулалт:

Оюунбаатар

Асуулт-4

Зорилго, алсын хараа, стратегийг тодорхой, ойлгомжтой байдлаар боловсруулж, ажилтнууд, иргэд болон бусад сонирхогч талуудыг тодорхойлох, хэрэгжүүлэх үйл явцад идэвхтэй оролцуулдаг.

Хариулт:

Зорилго, алсын харааг ажилтнуудтай уялдуулж, байгууллага даяар ойлгогдсон. Энэ нь байгууллагын хөгжлийн стратегийг боловсруулах, тактик, үйл ажиллагааг тодорхойлох боломжийг бүрдүүлдэг. Гэвч стратеги, зорилгыг дахин тодорхойлох үйл явцад байгууллага болгоомжтой ханддаг. Ажилтнуудын оролцоо хангалтгүй, сонирхогч талуудын оролцоо сул байна.

Баримтжуулалт:

Оюунбаатар

ЭКОСИСТЕМ, ЧАДАМЖ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа нь олон талт экосистемийн хүрээнд явагддаг. Экосистем нь байгууллагын дотоод болон гадаад орчинд нөлөөлдөг хүчин зүйлсийн нэгдэл юм. Байгууллагын өөрийн чадамж нь эдгээр хүчин зүйлсийг хэрхэн удирдаж, зохицуулж чадахаас хамаардаг.

Асуулт-5

Иргэд, бизнес, бусад төрийн байгууллага, төрийн бус байгууллага зэрэг гол оролцогч талуудыг тодорхойлж, тэдний хэрэгцээ, хүлээлтийг гүнзгий ойлгодог.

Хариулт:

Байгууллага гол оролцогч талуудын заримыг тодорхойлж, тэдний хэрэгцээ, хүлээлтийг ойлгох шаардлагатайг хүлээн зөвшөөрдөг. Гэвч оролцогч талуудын хэрэгцээг тодорхойлох, ойлгох системтэй арга барил хараахан нэвтрээгүй байна. Хэрэгцээг ойлгох судалгаа хааяа нэг хийгдэж болох ч, үр дүн нь үйл ажиллагаандаа бүрэн тусгагдаагүй байна.

Баримтжуулалт:

Гэрэлцолмон

Асуулт-6

Өөрийн дотоод хүчтэй болон сул талуудыг бүрэн дүүрэн үнэлж, хүний нөөц, санхүүгийн нөөц, технологийн чадавхи, байгууллагын бүтэц, соёл, үйл ажиллагааны процесс зэрэг бүхий л чадамжийн шинжилгээг тогтмол хийдэг.

Хариулт:

Байгууллага дотоод чадавхийн үнэлгээ хийх шаардлагатайг ойлгож эхэлж байна. Зарим тохиолдолд хүчтэй болон сул талуудыг тодорхойлох оролдлого хийдэг ч энэ нь системтэй бус, тохиолдлын чанартай байна. Үнэлгээ нь ихэвчлэн хүний нөөц болон санхүүгийн үндсэн нөөцөд төвлөрдөг. Бусад чадавхийн (технологи, бүтэц, соёл, процесс) шинжилгээ хангалтгүй эсвэл огт хийгддэггүй.

Баримтжуулалт:

Одбаяр

Асуулт-7

Тулгарч болзошгүй эдийн засгийн нөхцөл байдал, улс төрийн өөрчлөлт, нийгмийн чиг хандлага, технологийн хөгжил, хууль эрх зүйн өөрчлөлт, байгаль орчны асуудал зэрэг гадаад сорилтуудыг урьдчилан тодорхойлж, даван туулах арга замыг байнга эрэлхийлдэг.

Хариулт:

Байгууллага гадаад сорилтуудыг тодорхойлох, үнэлэх үндсэн процессыг бий болгосон. Эрсдэлийн үнэлгээ хийж, төлөвлөгөө боловсруулж эхэлсэн боловч процесс бүрэн төлөвшөөгүй, хэрэгжилт тогтвортой бус байж болно.

Баримтжуулалт:

Оюунбаатар

Асуулт-8

Иргэд, бизнес, бусад төрийн байгууллага, төрийн бус байгууллага зэрэг оролцогч талууд, өөрийн чадамж, гол сорилтуудын талаарх ойлголтоо тогтмол шинэчилж, шинжилгээ үнэлгээ хийх замаар өөрчлөлтөд дасан зохицох чадвараа байнга сайжруулдаг.

Хариулт:

Байгууллага оролцогч талууд, өөрийн чадамж, гол сорилтуудын талаар тодорхой ойлголттой болсон. Ойлголтоо шинэчлэх, шинжлэх, үнэлэх үйл ажиллагаа тогтмолжиж эхэлж байна. Өөрчлөлтөд дасан зохицох чадавх дунд түвшинд хүрсэн бөгөөд тодорхой хүрээнд өөрчлөлтөд дасан зохицож чаддаг болсон.

Баримтжуулалт:

Цэнгэл эгч

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛЖ, ОЙЛГОДОГ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд гол оролцогч талуудын хэрэгцээг тодорхойлж, ойлгох нь чухал ач холбогдолтой. Оролцогч талууд нь иргэд, бизнес эрхлэгчид, төрийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд зэрэг олон талт бүлгүүдийг хамардаг. Тэдний хэрэгцээ, хүлээлт,

асуудлыг ойлгож, шийдвэрлэх нь байгууллагын амжилт, үр дүнтэй байдалд шууд нөлөөлдөг.

Асуулт-9

Үйл ажиллагааныхаа хүрээнд хамааралтай бүх гол оролцогч талуудыг системтэйгээр тодорхойлж, ижил төстэй хэрэгцээ, хүлээлттэй бүлэгт хувааж бодлогын түвшинд анхаардаг.

Хариулт:

Байгууллага гол оролцогч талуудыг тодорхойлохдоо илүү системтэй хандаж, ижил төстэй хэрэгцээ, хүлээлттэй бүлгүүдэд хувааж эхэлж байна. Оролцогч талуудын хэрэгцээ, хүлээлтийг ойлгохын тулд судалгаа, санал асуулга зэрэг арга хэрэгслийг ашигладаг. Бодлогын түвшинд оролцогч талуудын хэрэгцээг харгалзан үзэж, холбогдох бодлогыг боловсруулдаг.

Баримтжуулалт:

Гэрэлцолмон

Асуулт-10

Оролцогч талуудтай тогтмол, идэвхтэй харилцааг бий болгож, уулзалт, хэлэлцүүлэг, судалгаа, цахим сувгууд зэрэг олон янзын арга хэрэгслээр тэдний санал хүсэлтийг сонсож, хүлээн авдаг.

Хариулт:

Оролцогч талуудын хэрэгцээг тогтмол тодорхойлж, ойлгохыг эрмэлздэг. Оролцогч талуудтай уулзалт, хэлэлцүүлэг, судалгаа зэрэг төрөл бүрийн арга хэрэгсэл ашиглаж эхэлж байна. Санал хүсэлтийг цуглуулан анхан шатны дүн шинжилгээ хийдэг боловч бүрэн дүүрэн ашиглах нь хангалтгүй байна.

Баримтжуулалт:

Гэрэлцолмон

Асуулт-11

Оролцогч талуудаас цуглуулсан мэдээлэлд тоон болон чанарын аргаар дүн шинжилгээ хийж, тэдний хэрэгцээ, хүлээлтийг гүнзгий ойлгодог.

Хариулт:

Оролцогч талуудын хэрэгцээг тодорхойлох, ойлгохын ач холбогдлыг ухамсарлаж эхэлсэн ч хараахан системтэй арга барилыг нэвтрүүлээгүй байна. Оролцогч талуудаас мэдээлэл цуглуулах ажлыг хааяа нэг хийдэг боловч, цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх, тэдний хэрэгцээг гүнзгий ойлгох тал дээр дутагдалтай. Мэдээлэл цуглуулах үйл явц нь ихэвчлэн чанарын бус, санамсаргүй хэлбэрээр явагддаг.

Баримтжуулалт:

Гэрэлцолмон

Асуулт-12

Оролцогч талуудын хэрэгцээг ойлгосны үндсэн дээр үйл ажиллагаандаа хариу үйлдэл үзүүлж, үйлчилгээгээ тасралтгүй сайжруулан, тэдний хүлээлтэд бүрэн нийцүүлдэг.

Хариулт:

Байгууллага гол оролцогч талуудын хэрэгцээг тодорхойлох, ойлгох зорилготой тодорхой процессуудыг бий болгосон. Хэрэгцээг тодорхойлохдоо судалгаа, санал асуулга зэрэг арга хэрэгслийг ашигладаг. Оролцогч талуудын хэрэгцээнд хариу өгч, үйлчилгээг сайжруулах төлөвлөгөө хэрэгжүүлдэг ч үйл ажиллагаа нь бүрэн төгөлдөр болоогүй байна.

Баримтжуулалт:

Гэрэлцолмон

СТРАТЕГИ БА ДАСАН ЗОХИЦОХ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь үр дүнтэй стратеги боловсруулж, өөрчлөлтөд дасан зохицох чадвараас хамаардаг. Стратеги нь байгууллагын зорилго, алсын харааг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө юм. Дасан зохицох чадвар нь байгууллагын гадаад, дотоод орчны өөрчлөлтөд хурдан, үр дүнтэй хариу үйлдэл үзүүлэх чадвар юм.

Асуулт-13

Стратеги боловсруулахдаа бодит нотолгоо, судалгаанд үндэслэж, иргэд, бизнес, ажилтнууд, бусад байгууллага зэрэг гол оролцогч талуудын оролцоог хангаж, тэдний санал бодлыг бүрэн тусгадаг.

Хариулт:

Стратеги боловсруулах тодорхой процесс бий болж, судалгаа, нотолгоонд суурилж, оролцогч талуудыг тодорхой хэмжээнд оролцуулдаг. Санал бодлыг нь цуглуулж, стратегийн төсөлд тусгахыг эрмэлздэг ч бүрэн дүүрэн тусгаж чаддаггүй.

Баримтжуулалт:

Оюунбаатар

Асуулт-14

Стратеги нь нийтийн үнэ цэнэ, бодлогод нийцсэн хэрэгжүүлэх боломжтой, хэмжигдэхүйц, хүрэхүйц, бодит, цаг хугацааны тодорхой хязгаартай байх зарчмуудыг хангасан SMART шалгуурын дагуу боловсруулдаг.

Хариулт:

SMART шалгуурт нийцсэн стратеги боловсруулах оролдлого хийгдэж, тодорхой хэмжээнд хэмжигдэхүйц, хүрэхүйц зорилтуудыг агуулсан ч энэхүү стратеги нь байгууллагын бүхий л үйл ажиллагаанд бүрэн нэвтэрч чадсангүй.

Баримтжуулалт:

Одбаяр

Асуулт-15

Стратегийг SMART шалгуурын дагуу боловсруулж, хэрэгжүүлэх тодорхой төлөвлөгөө гарган, шаардлагатай нөөцийг хуваарилж, байгууллагын бүтэц, үйл ажиллагааг стратегитай бүрэн уялдуулан зохион байгуулдаг.

Хариулт:

Стратеги боловсруулалт дунд шатандаа байна. Байгууллага SMART шалгуурын дагуу стратеги боловсруулахыг зорьж, хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, нөөцийг хуваарилах

оролдлого хийж эхэлсэн. Байгууллагын бүтэц, үйл ажиллагааг стратегитай уялдуулах ажил эхэлсэн ч хараахан бүрэн төгс болоогүй байна.

Баримтжуулалт:

Золоо

Асуулт-16

Стратегийн хэрэгжилтийг тогтмол хянаж, үр дүнг үнэлэн, гадаад орчин, дотоод нөхцөл байдал өөрчлөгдөхөд стратегиа цаг алдалгүй дасан зохицуулж, уян хатан байдлыг хангадаг.

Хариулт:

Стратеги боловсруулсан ч албан ёсоор батлагдаагүй эсвэл хэрэгжилт нь хангалтгүй байна. Гадаад, дотоод орчны өөрчлөлтийг мэдэрдэг боловч дасан зохицох чадвар сул. Төлөвлөгөө гаргадаг ч хэрэгжилтэд нь төдийлөн анхаарал хандуулдаггүй.

Баримтжуулалт:

Оюунбаатар

ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГА, ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦОО

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь үр дүнтэй гүйцэтгэлийн удирдлага, засаглалын тогтолцооноос хамаардаг. Гүйцэтгэлийн удирдлага нь байгууллагын зорилго, стратегийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө, хяналт, үнэлгээний систем юм. Засаглалын тогтолцоо нь байгууллагын үйл ажиллагааг зохицуулж, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн бүтэц, процесс, дүрэм журам, хяналтын механизм юм.

Асуулт-17

Гүйцэтгэлийн удирдлага, засаглалын тогтолцоог стратегийн зорилготой бүрэн уялдуулан, нийтийн үнэ цэнэ, иргэдэд үйлчлэхэд чиглүүлдэг.

Хариулт:

Гүйцэтгэлийн удирдлага, засаглалын тогтолцоо тодорхой түвшинд хөгжиж, стратегийн зорилготой уялдахад хүчин чармайлт гаргаж байна. Нийтийн үнэ цэнэ, иргэдэд үйлчлэхэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт эхэлж, тогтолцоо мэргэжлийн түвшинд хүрэх, чанарын баталгааг хангах үндэс суурь тавигдаж байна.

Баримтжуулалт:

Оюунбаатар

Асуулт-18

Гүйцэтгэлийн удирдлага, засаглалын тогтолцоог ил тод, нээлттэй байлгаж, гүйцэтгэлийг хэмжих үзүүлэлтүүд, хяналтын механизм, хариуцлагын тогтолцоог тодорхой болгон, бүх оролцогч талуудад хүртээмжтэй байдлаар нэвтрүүлдэг.

Хариулт:

Гүйцэтгэлийн удирдлага, засаглалын тогтолцоо тодорхой түвшинд бүрэлдэн тогтож, гүйцэтгэлийг хэмжих үзүүлэлтүүд, хяналтын механизм, хариуцлагын тогтолцоо үндсэндээ тодорхой болсон. Ил тод, нээлттэй байдал хангагдаж, оролцогч талууд мэдээлэлд

харьцангуй хүртээмжтэй болсон. Гүйцэтгэлийн удирдлага тогтмол хэрэгждэг боловч бүрэн төгс бус байна.

Баримтжуулалт:

Одбаяр

Асуулт-19

Гүйцэтгэлийн удирдлага, засаглалын тогтолцоог тасралтгүй сайжруулах зарчимд үндэслэн, үр дүнг тогтмол хянаж, үнэлж, сургамж авч, өөрчлөлтөд дасан зохицож, динамик, уян хатан байдлыг хангадаг.

Хариулт:

Гүйцэтгэлийн удирдлага, засаглалын үндсэн тогтолцооны эхлэл тавигдаж байгаа боловч үр дүнг хянах, үнэлэх, сайжруулах үйл явц бүрэн хэрэгжээгүй байна. Байгууллага өөрчлөлтөд дасан зохицох, уян хатан байдлыг хангах шаардлагатайг ойлгож байгаа боловч үүнийг системтэйгээр хэрэгжүүлж чадахгүй байна. Энэ нь байгууллагын үйл ажиллагааг төгс удирдах, дасан зохицох чадварыг дээшлүүлэхэд саад болж байна.

Баримтжуулалт:

Оюунбаатар

Асуулт-20

Гүйцэтгэлийн удирдлага, засаглалын тогтолцоо нь ажилтнуудын оролцоог дэмжиж, дотоод болон гадаад оролцогч талуудтай хамтран ажиллах, санал бодлыг нь харгалзан үзэх боломжийг хангадаг.

Хариулт:

Гүйцэтгэлийн удирдлага, засаглалын тогтолцоог тодорхой хэмжээнд хэрэгжүүлснээр байгууллага нь ажилтнуудын оролцоог идэвхтэй дэмжиж, оролцогч талуудын санал бодлыг харгалзан үзэх үйл явцыг зохион байгуулснаар дотоод, гадаад талуудтай хамтран ажиллах хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэн, уялдаа холбоог сайжруулахыг эрмэлздэг.

Баримтжуулалт:

Гэрэлцолмон эгч

БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ, ҮНДСЭН ҮНЭТ ЗҮЙЛ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь байгууллагын соёлыг удирдаж, үндсэн үнэт зүйлсийг хөгжүүлэхээс хамаардаг. Байгууллагын соёл нь ажилтнуудын хандлага, зан төлөв, харилцаа, хамтын ажиллагааг тодорхойлдог. Үндсэн үнэт зүйлс нь байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, стратегийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зарчим, хэм хэмжээ юм.

Асуулт-21

Байгууллагын удирдлага, манлайлагчид нь байгууллагын хүссэн соёлыг бий болгох, төлөвшүүлэх, хөгжүүлэхэд идэвхтэй үүрэг оролцоотой байж, үлгэрлэн манлайлдаг.

Хариулт:

Байгууллагын удирдлага хүссэн соёлоо тодорхойлж, ажилтнуудын дунд өргөн хүрээнд ойлголцол, зөвшилцөлд хүрсэн байна. Соёлыг хөгжүүлэхэд чиглэсэн цогц системтэй хөтөлбөр, үйл ажиллагааг төлөвлөж, тогтмол хэрэгжүүлж, үр дүнг нь хэмжиж, үнэлж, сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Манлайлагчид үлгэрлэн манлайлж, соёлыг байгууллагын бүхий л түвшинд төлөвшүүлж байна.

Баримтжуулалт:

Оюунбаатар

Асуулт-22

Байгууллага албан хаагчдын бүтээлч, санаачилгатай ажиллах, хамтран ажиллах, бие биенээ хүндэтгэх, дэмжих, хөгжихөд чиглэсэн ажил хэрэгч, нээлттэй, харилцан итгэлцсэн, хүний эрхийг дээдэлсэн эерэг соёлын орчин бүрдүүлдэг.

Хариулт:

Байгууллага эерэг соёлыг идэвхтэй удирдаж, хөгжүүлэхийг эрмэлздэг. Үндсэн үнэт зүйлсийг тодорхойлж, албан хаагчдад таниулсан. Эерэг соёлыг дэмжих хөтөлбөр, журам боловсруулж хэрэгжүүлж эхэлсэн. Бүтээлч байдал, санаачилга, хамтын ажиллагаа, харилцан хүндэтгэл зэрэг эерэг соёлын элементүүд байгууллагад нэвтэрч, тодорхой хэмжээнд хөгжиж байна. Соёлын өөрчлөлтөд зарим саад бэрхшээл тулгарч байгаа боловч байгууллага зорилгодоо хүрэхийн төлөө тууштай ажиллаж байна.

Баримтжуулалт:

Золоо

Асуулт-23

Байгууллагын үнэт зүйлсийг тодорхой, энгийн, ойлгомжтой томъёолж, ажилтнууддаа өргөнөөр түгээж, ойлгуулж, өдөр тутмын үйл ажиллагаа, шийдвэр гаргалт, зан төлөвт нь бүрэн шингээдэг.

Хариулт:

Байгууллагын үнэт зүйлс тодорхой, энгийн, ойлгомжтой томъёологдсон. Ажилтнуудад хангалттай түгээж, ойлгуулсан. Үнэт зүйлс нь байгууллагын үйл ажиллагааны тодорхой хэсэгт нөлөөлж эхэлсэн боловч, бүх ажилтны өдөр тутмын үйл ажиллагаа, шийдвэр гаргалт, зан төлөвт бүрэн дүүрэн шингэж амжаагүй байна. Үнэт зүйлсийг хэрэгжүүлэх, сахин мөрдүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Баримтжуулалт:

Золоо

Асуулт-24

Байгууллага өөрийн хүссэн соёлдоо хүрч байгаа эсэхээ тогтмол хянаж, соёлын үнэлгээ хийж, ажилтнуудын санал бодлыг сонсон, сургамж авч, соёлыг тасралтгүй сайжруулан хөгжүүлэх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлдэг.

Хариулт:

Байгууллага соёлын ач холбогдлыг ойлгож эхэлж байгаа боловч системтэй удирдлага, хөгжүүлэлт байхгүй. Соёлын талаарх үнэлгээ, ажилтнуудын санал бодлыг цуглуулах ажлыг хааяа хийдэг боловч үр дүнг бүрэн ашигладаггүй. Санамсаргүй байдлаар сайжруулах арга хэмжээ авч болзошгүй.

Баримтжуулалт:

ӨӨРЧЛӨЛТ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь өөрчлөлтийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхээс хамаардаг. Өөрчлөлт нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, тогтвортой байдалд нөлөөлдөг.

Асуулт-25

Байгууллагын удирдлага, манлайлагчид өөрчлөлтийг манлайлахдаа тодорхой алсын харааг ажилтнууд болон оролцогч талуудад ойлгомжтой хүргэж, өөрчлөлтийг дэмжихэд нь идэвхтэй чиглүүлдэг.

Хариулт:

Байгууллагын удирдлага, манлайлагчид нь өөрчлөлтийг манлайлах үйлсэд тодорхой алсын харааг ажилтнууд болон оролцогч талуудад ойлгомжтой хүргэж, өөрчлөлтийг дэмжихэд нь идэвхтэй чиглүүлж байна. Алсын хараа нь байгууллагын хэмжээнд ойлгогдож, өөрчлөлтийг хэрэгжүүлэх стратеги боловсруулагдаж эхэлсэн бөгөөд улмаар ажилтнууд өөрчлөлтийг дэмжих үйл ажиллагаанд тодорхой хэмжээний оролцоог хангаж байна.

Баримтжуулалт:

Оюунбаатар

Асуулт-26

Өөрчлөлтийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд удирдлага, манлайлагчид ажилтнууд болон өөрчлөлтөд холбогдох бүх оролцогч талуудыг өөрчлөлтийн үйл явцад идэвхтэй оролцуулж, тэдний саналыг сонсож, дэмжлэг авдаг.

Хариулт:

Удирдлагаас өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд ажилтнуудын оролцоог хангахын чухлыг ухамсарлан тодорхой хүчин чармайлт гаргаж эхэлж байгаа нь ажиглагдаж байна. Гэсэн хэдий ч өөрчлөлтийн үйл явцын талаар ажилтнууд болон оролцогч талуудтай харилцан санал солилцох, тэдний саналыг сонсох, мөн дэмжлэг авах чиглэлд гаргаж буй оролдлого нь хараахан тогтмол, системтэй хэлбэрт шилжээгүй байна. Түүнчлэн өөрчлөлтийн үйл явц нь үндсэндээ төлөвлөгөөтэй боловч, төлөвлөгөө нь бүрэн бус бөгөөд хангалттай уян хатан биш байх төлөвтэй байгаа нь ажиглагддаг.

Баримтжуулалт:

Одбаяр

Асуулт-27

Өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд байгууллагын бүтэц, процессыг уян хатан, дэмжлэг үзүүлэхүйц байдлаар бүрдүүлж, шаардлагатай тохиолдолд тохируулга хийж, нөөцийг үр ашигтай хуваарилж, хэрэгжилтийг хянадаг.

Хариулт:

Байгууллагын бүтэц, үйл явц нь өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд хангалттай дэмжлэг үзүүлэхүйц уян хатан, тохируулагдах боломжтойгоос гадна нөөцийг үр ашигтай хуваарилах системтэй, өөрчлөлтийн хэрэгжилтийг хянах тогтолцоог нэвтрүүлж эхэлсэн байна.

Баримтжуулалт:
Оюунбаатар

Асуулт-28

Өөрчлөлттэй холбоотой ажилтнуудыг зохих сургалтад хамруулж, мэдлэг, чадварыг дээшлүүлэн, өөрчлөлтийн талаарх мэдээллийг тогтмол, үр дүнтэй аргаар бүх ажилтнууд болон оролцогч талуудад хүргэж, харилцаа холбоог идэвхтэй хөгжүүлэн өөрчлөлтийг амжилттай хэрэгжүүлдэг.

Хариулт:

Байгууллага нь өөрчлөлтийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд ажилтнуудаа сурган, мэдээллээр хангах нь нэн чухал гэдгийг ухамсарлан, тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж эхэлж буй нь ажиглагдаж байна. Түүнчлэн өөрчлөлттэй холбоотой ажилтнуудыг зохих сургалтад хамруулан, мэдлэг чадварыг нь дээшлүүлэхэд анхаарал хандуулан ажиллаж байна. Мөн түүнчлэн өөрчлөлтийн талаарх мэдээллийг тогтмол хүргэж, харилцаа холбоог хөгжүүлэхийг эрмэлзэн ажиллаж байгаа нь харагдаж байна. Ийнхүү ажилтнуудын оролцоо нэмэгдэж, өөрчлөлтийг хэрэгжүүлэх үйл явц ахиц дэвшилтэй байгаа нь сайшаалтай.

Баримтжуулалт:
Золоо

БҮТЭЭЛЧ БАЙДАЛ, ИННОВАЦИ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь бүтээлч байдал, инновацийг дэмжихээс хамаардаг. Бүтээлч байдал нь шинэ санаа, шийдлийг гаргаж ирэх чадвар бөгөөд инноваци нь эдгээр санааг бодит үйл ажиллагаанд хэрэгжүүлэх үйл явц юм.

Асуулт-29

Байгууллагын удирдлага, манлайлагчид бүтээлч байдал, инновацийг хөгжүүлэхэд бүхий л талаар дэмжлэг үзүүлдэг.

Хариулт:

Байгууллагын удирдлага, манлайлагчид нь бүтээлч байдал, инновацийг дэмжих чиглэлд тодорхой алхмууд хэрэгжүүлж эхлээд байгаагийн зэрэгцээгээр бүтээлч санааг цуглуулах, хэлэлцэх боломжийг бий болгож, зарим санааг турших, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг болсон хэдий ч эдгээр нь системтэй, тогтвортой, бүрэн утгаараа хэвшсэн үйл ажиллагаа болоогүй байна.

Баримтжуулалт:
Оюунбаатар

Асуулт-30

Байгууллага бүтээлч санааг дэмжих, гаргах, цуглуулах, үнэлэх, турших, хэрэгжүүлэх тодорхой механизм, процессыг санаачлагын санал, хакатон, инновацийн хөтөлбөр, платформ, нээлттэй инновацийн арга хэмжээ зэрэг төрөл бүрийн арга хэрэгслээр дамжуулан бий болгодог.

Хариулт:

Байгууллага нь бүтээлч байдал, инновацийг дэмжих шаардлагатайг ухамсарлан, санаачлагын санал авах хайрцаг болон хакатоны тухай мэдээлэл зэрэг энгийн арга замуудыг туршилтын журмаар нэвтрүүлж эхэлж байгаа боловч эдгээр нь хараахан тогтолцоотой, байнгын үйл ажиллагааны хэлбэрт шилжээгүй байна.

Баримтжуулалт:

Оюунбаатар

Асуулт-31

Байгууллага албан хаагчдын хамтын ажиллагааг дэмжих, хөндлөнгийн уялдаа холбоог сайжруулах, мэдлэг, туршлагаа хуваалцах, гадаад байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах замаар нээлттэй инновацийн экосистемийг бүрдүүлж, хөгжүүлдэг.

Хариулт:

Албан хаагчдын хамтын ажиллагааг дэмжих, мэдлэг хуваалцах зорилгоор тодорхой журам, заавар боловсруулан хэрэгжүүлж байгаа хэдий ч тэдгээрийн хэрэгжилт хангалтгүй, тогтмол бус байгаа нь ажиглагдаж байна. Мөн түүнчлэн, хөндлөнгийн уялдаа холбоог сайжруулах, гадаад байгууллагатай хамтран ажиллах чиглэлд тодорхой эхлэл тавигдаж, нээлттэй инновацийн экосистемийг бүрдүүлэхэд чиглэсэн зарим алхмууд хэрэгжиж байна.

Баримтжуулалт:

Гээцоо эгч

Асуулт-32

Байгууллага туршилт хийх, шинэ зүйл оролдох, алдаа гаргахаас эмээхгүй байх, алдааг сургамж болгон ашиглах, тасралтгүй суралцах соёлыг бүрэн дүүрэн дэмждэг.

Хариулт:

Байгууллагаас бүтээлч байдал, инновацийг дэмжих чиглэлд тодорхой алхмууд авч хэрэгжүүлж эхэлсэн хэдий ч эрсдэлээс зайлсхийх хандлага ажиглагдаж, туршилт хийх, шинэ зүйл оролдохыг дэмждэг боловч хангалттай түвшинд хүрээгүй байна. Мөн алдааг сургамж болгон ашиглах, тасралтгүй суралцах соёлыг хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй байгаа хэдий ч байгууллагын зүгээс үзүүлж буй дэмжлэг хангалттай бус байна.

Баримтжуулалт:

Золоо

ЗОРИЛГО, АЛСЫН ХАРАА, СТРАТЕГИ БОЛОВСРУУЛАХДАА ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ НЭГТГЭЖ, ОРОЛЦУУЛДАГ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь зорилго, алсын хараа, стратеги боловсруулахдаа оролцогч талуудыг нэгтгэж, оролцуулах чадвараас хамаардаг. Оролцогч талууд нь иргэд, бизнес эрхлэгчид, төрийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд зэрэг олон талт бүлгүүдийг хамардаг. Тэдний хэрэгцээ, хүлээлт, асуудлыг ойлгож, шийдвэрлэх нь байгууллагын амжилт, үр дүнтэй байдалд шууд нөлөөлдөг.

Асуулт-33

Байгууллага өөрийн зорилго, алсын хараа, стратегийг бүх гол оролцогч талуудад ойлгомжтой, хүртээмжтэй, ил тод аргаар тогтмол хүргэж, тэднийг мэдээллээр хангаж, оролцоог дэмжин, харилцан ойлголцох нөхцөлийг бүрдүүлдэг.

Хариулт:

Байгууллагын зорилго, алсын харааг ажилтнуудтайгаа уялдуулан тодорхойлж, байгууллагын хүрээнд бүрэн ойлгогдохуйц болсон байна. Зорилго, алсын хараа нь байгууллагын хөгжлийн стратегийг боловсруулах, түүний тактик, үйл ажиллагааг тодорхойлох боломжийг хангадаг. Гол оролцогч талуудад мэдээлэл хүргэх, тэдний оролцоог нэмэгдүүлэх чиглэлд тодорхой ахиц дэвшил гаргасан хэдий ч энэ нь тогтмол, бүрэн дүүрэн хэмжээнд хүрч чадаагүй байна. Стратеги, зорилгоо дахин тодорхойлох боломжийг хязгаарлагдмал хүрээнд хүлээн зөвшөөрдөг.

Баримтжуулалт:

Оюунбаатар

Асуулт-34

Байгууллага гол оролцогч талуудын дунд зорилго, алсын хараа, стратегийн талаар нэгдмэл ойлголт бий болгож, тэднийг эдгээр зорилгыг хуваалцан, өөрийн зорилго мэт хүлээн авч, байгууллагын үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулах урам зоригийг төрүүлж, нийтлэг үнэ цэнийг бий болгохын төлөө ажилладаг.

Хариулт:

Байгууллага нь зорилго, алсын хараагаа ажилтнуудтайгаа уялдуулан, байгууллагын хүрээнд харилцан ойлголцох эхлэл тавьж байгаа нь байгууллагын хөгжлийн стратегийг боловсруулах, тактик, үйл ажиллагааг тодорхойлох боломжийг бүрдүүлж өгч байна. Мөн түүнчлэн гол оролцогч талуудтай харилцаа холбоо тогтоож, тэдний ойлголт, дэмжлэгийг бэхжүүлэхэд анхаарч ажиллаж байгаа хэдий ч, стратеги, зорилгоо дахин тодорхойлох шаардлагатай нөхцөл байдал үүссэн тохиолдолд болгоомжтой хандаж, өөрчлөлтийг аажмаар хүлээн зөвшөөрдөг хандлага ажиглагдаж байна.

Баримтжуулалт:

Оюунбаатар

Асуулт-35

Байгууллага гол оролцогч талуудыг зорилго, алсын хараа, стратегитайгаа нэгтгэж, хэлэлцүүлэг, уулзалт, судалгаа, цахим санал асуулга, хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөр, зөвлөлдөх зөвлөл зэрэг төрөл бүрийн арга хэрэгслээр оролцоог нь өргөжүүлж, идэвхжүүлэн, дуу хоолойг нь сонсож, харгалзан үздэг.

Хариулт:

Байгууллага нь оролцогч талуудын оролцооны ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, тэдгээрийг идэвхтэй оролцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлж эхэлж байна. Оролцогч талуудын дуу хоолойг сонсож, тэдний саналыг стратегийн шийдвэрт тусгах зорилгоор зөвлөлдөх уулзалт, санал асуулга болон бусад арга хэрэгслийг ашигладаг. Оролцоог нэмэгдүүлэх чиглэлд хүчин чармайлт гаргаж байгаа хэдий ч энэ нь бүрэн дүүрэн хэрэгжиж амжаагүй байна.

Баримтжуулалт:

Гээцоо эгч

Асуулт-36

Байгууллага оролцогч талуудын оролцооны үр дүнд тогтмол эргэх холбоо тогтоож, тэдний хувь нэмрийг үнэлж, талархал илэрхийлж, хүлээн зөвшөөрч, урамшуулан, оролцоог үргэлжлүүлэн, цаашдын хамтын ажиллагааг дэмждэг.

Хариулт:

Байгууллага оролцогч талуудын ач холбогдлыг ухамсарлаж эхэлж байгаа хэдий ч тэдний оролцоо хариу үйлдэл үзүүлэх шинжтэй, тогтмол бус байна. Санал хүсэлтийг хааяа цуглуулдаг бөгөөд гол төлөв асуудал үүссэний дараа авч хэрэгжүүлдэг. Мөн талархал, урамшууллыг хааяа, тохиолдлын шинжтэйгээр илэрхийлдэг.

Баримтжуулалт:

Гээцөө эгч

ИРГЭД (үйлчлүүлэгчид) – ТОГТВОРТОЙ ХАРИЛЦААГ ТОГТООХ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь иргэдтэй тогтвортой харилцааг бий болгох чадвараас хамаардаг. Иргэдийн оролцоо, санаачилгыг дэмжих нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, тогтвортой байдалд чухал ач холбогдолтой.

Асуулт-37

Байгууллага иргэдийн үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжтэй байдал, шуурхай байдал, мэдээллийн хэрэгцээ зэрэг олон янзын хэрэгцээ, хүлээлтийг гүнзгий ойлгож, иргэдийн саналыг тогтмол сонсох, судалгаа хийх, хэрэглэгчийн мэдээллийг цуглуулах замаар нарийвчлан тодорхойлдог.

Хариулт:

Байгууллага нь иргэдийн хэрэгцээ, хүлээлтийг ойлгох зорилгоор тодорхой арга зүй, процессуудыг нэвтрүүлж, иргэдийн саналыг тогтмол авах, судалгаа хийх, мэдээлэл цуглуулах зэрэг ажлууд төлөвлөгөөний дагуу хэрэгжин, үр дүнг шинжилж үйл ажиллагаандаа тусгахыг эрмэлзэж байна. Гэсэн хэдий ч эдгээр процессууд нь бүрэн төгөлдөр болоогүй бөгөөд цаашид сайжруулах шаардлагатай хэвээр байна.

Баримтжуулалт:

Гээцөө эгч

Асуулт-38

Байгууллага иргэдтэй тогтмол, идэвхтэй харилцаа холбоо тогтоож, санал хүсэлтийг нь хүлээн авч, мэдээллээр хангаж, асуудал, гомдлыг шийдвэрлэж, үйлчилгээний талаар санал солилцох нээлттэй, олон сувгийн харилцааны тогтолцоог бүрдүүлдэг.

Хариулт:

Байгууллага нь иргэдтэй харилцах тодорхой сувгуудыг, тухайлбал вэбсайт, сошиал медиа болон санал асуулгын маягтуудыг бий болгож ашиглалтад нэвтрүүлэн, идэвхтэй мэдээлэл түгээх ажлыг эрчимжүүлж, санал хүсэлтийг тодорхой бүтэц, зохион байгуулалтын хүрээнд системтэйгээр цуглуулан анхан шатны шинжилгээг гүйцэтгэж байна. Асуудал, гомдлыг шийдвэрлэх үйл ажиллагаа тогтвортой төлөвшиж, тодорхой процессийн дагуу үе шаттайгаар хэрэгжиж эхэлсэн бөгөөд үйлчилгээний талаар санал солилцох боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үүсгэн хэрэгжүүлж байна.

Баримтжуулалт:

Гээцөө эгч

Асуулт-39

Байгууллага иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанарыг байнга сайжруулж, стандартад нийцсэн, хүлээлтэд хүрсэн, хүндрэлгүй, хүртээмжтэй, үнэ цэнтэй үйлчилгээг тогтмол үзүүлдэг.

Хариулт:

Үндсэн процессуудын эхлэл үе шатанд байгууллага үйлчилгээний чанарыг сайжруулахын чухлыг ухамсарлаж эхэлж байгаа боловч системтэй арга барил хараахан бүрэлдэн тогтоогүй, зарим үндсэн процессууд тодорхойлогдож эхэлсэн хэдий ч бүрэн хэрэгжээгүй, стандарт, хүлээлтэд хүрэх анхны оролдлогууд хийгдэж байна.

Баримтжуулалт:

Гээцөө эгч

Асуулт-40

Иргэдээс ирсэн санал хүсэлтийг бүртгэж, дүн шинжилгээ хийж, үнэлж, үйл ажиллагаандаа зохих өөрчлөлт, сайжруулалт хийж, эргэх холбоо өгч, үйлчилгээг сайжруулах тасралтгүй үйл явцыг бий болгон хэрэгжүүлдэг.

Хариулт:

Иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийг бүртгэх, дүн шинжилгээ хийх, үнэлэхэд чиглэсэн боловсронгуй үйл явц бүрэн утгаараа хэрэгжиж, тодорхой үр дүнгээ үзүүлж байна. Иргэдээс санал хүсэлтийг идэвхтэй арга замаар цуглуулан, бүртгэлжүүлж, гүнзгийрүүлэн дүн шинжилгээ хийж, сайтар үнэлэн, үйл ажиллагаандаа цаг алдалгүй өөрчлөлт, сайжруулалт хийгдэж байна. Эргэх холбоог цаг тухайд нь болон үр дүнтэй хэлбэрээр хангаж, үйлчилгээг сайжруулах тасралтгүй үйл ажиллагаа тогтвортойгоор хэрэгжиж байна. Уг үйл явц нь байнга сайжруулагдаж, улам бүр боловсронгуй болж байгаа нь ажиглагдаж байна.

Баримтжуулалт:

Гэрэлцолмон

АЛБАН ХААГЧДЫГ ТАТАХ, ОРОЛЦУУЛАХ, ХӨГЖҮҮЛЭХ, ХАДГАЛАХ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь албан хаагчдыг татах, оролцуулах, хөгжүүлэх, хадгалах чадвараас хамаардаг. Албан хаагчид нь байгууллагын гол хөдөлгөгч хүч бөгөөд тэдний ур чадвар, хандлага, оролцоо нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, тогтвортой байдалд чухал ач холбогдолтой.

Асуулт-41

Байгууллагын өвөрмөц үнэ цэнэ, давуу талыг тодотгосон хүчтэй ажил олгогчийн брэндийг бий болгож, зорилтот бүлэгт чиглэсэн үр дүнтэй сурталчилгааны арга хэмжээг хэрэгжүүлэн ажил горилогчдыг идэвхтэй татдаг.

Хариулт:

Ажил олгогчийн брэндийн тухай ойлголт бүрэлдэн төлөвшиж буй эхний шатанд байна. Байгууллагын үнэ цэнэ, давуу талыг тодорхойлох анхны оролдлогууд хийгдэж байгаа хэдий ч сурталчилгааны үйл ажиллагаа нь тогтмол бус, системгүй хэлбэрээр явагддаг.

Баримтжуулалт:

Золоо

Асуулт-42

Байгууллага ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан амьдрах нөхцөлийг хангасан эерэг, дэмжлэг үзүүлдэг ажлын байрны орчин бүрдүүлж, ажлын ачааллыг оновчтой зохицуулж, ажлын болон хувийн амьдралын тэнцвэрийг хадгалах, дэмжих бодлогыг хэрэгжүүлдэг.

Хариулт:

Байгууллага нь ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгмийн халамжийг дээшлүүлэх, ажлын ачааллыг оновчтой зохион байгуулах, ажил, амьдралын тэнцвэрийг хангах чиглэлд цогц бодлого, журам, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, тэдгээрийг тогтмол сайжруулан, үр дүнг хэмжин үнэлж, байгууллагын соёлд нэвтрүүлсэн байна. Мөн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах идэвхтэй арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Баримтжуулалт:

Золоо

Асуулт-43

Албан хаагчдыг хөгжүүлэх хөтөлбөр, сургалт, менторшип, ажлын байран дахь суралцах боломжуудыг олгож, ажилтнуудын санаачилгыг дэмжин, үйл ажиллагаанд идэвхтэй оролцох ээлтэй орчныг бүрдүүлэн төрийн албан хаагчдыг хөгжүүлж, ур чадварыг дээшлүүлж, мэргэжлийн өсөлтөд нь дэмжлэг үзүүлдэг.

Хариулт:

Албан хаагчдыг хөгжүүлэх бодлого, хөтөлбөр байгууллагын хэмжээнд тодорхой болж, ойлгогдож, хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд хөгжлийн стратеги боловсруулагдан, тактик, үйл ажиллагаа тодорхойлогдсон төдийгүй сургалт, хөгжлийн хөтөлбөрүүд тогтмол хэрэгжиж, менторшип болон ажлын байран дахь суралцах боломжууд бий болж эхэлсэн хэдий ч стратеги, зорилгоо дахин тодорхойлох, өөрчлөхөд хүндрэлтэй хэвээр байна.

Баримтжуулалт:

Золоо

Асуулт-44

Байгууллага албан хаагчдын гүйцэтгэл, үр дүнд суурилсан шударга цалин, урамшуулал, шагнал урамшууллын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэн, тэдний хувь нэмрийг тогтмол үнэлж, хүлээн зөвшөөрч, талархал илэрхийлдэг.

Хариулт:

Байгууллагад гүйцэтгэл, үр дүнд суурилсан цалин, урамшууллын тогтолцоо бүрдэн тогтож, хэрэгжилт нь үндсэндээ хангагдаж байна. Уг тогтолцооны зарчим, үйл ажиллагааны талаарх ойлголт албан хаагчдад бүрэн дүүрэн төлөвшсөн. Албан хаагчдын оруулсан хувь нэмрийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, талархал илэрхийлэх үйл ажиллагаа тогтмол хэрэгжиж эхэлсэн хэдий ч, үр өгөөжийг дээшлүүлэх чиглэлд анхаарах асуудал байгаа нь ажиглагдаж байна.

Баримтжуулалт:

Золоо

БИЗНЕС БА ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ОРОЛЦОГЧИД- ТОГТВОРТОЙ ДЭМЖЛЭГИЙГ ХАНГАХ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь бизнес ба захиргааны оролцогч талуудын тогтвортой дэмжлэгийг хангахаас хамаардаг. Бизнес эрхлэгчид, төрийн захиргааны байгууллагууд нь нийслэлийн хөгжил, эдийн засгийн өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэдний дэмжлэг, хамтын ажиллагаа нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, тогтвортой байдалд чухал ач холбогдолтой.

Асуулт-45

Байгууллага бизнес эрхлэгчид, хувийн хэвшил болон бусад захиргааны байгууллагуудын үйлчилгээний чанар, цаг хугацаа, журам, мэдээлэл, хамтын ажиллагаа зэрэг олон янзын хэрэгцээ, хүлээлтийг гүнзгий ойлгож, тэдний саналыг тогтмол сонсох, судалгаа хийх, харилцааны үр дүнг үнэлэх замаар нарийвчлан тодорхойлдог.

Хариулт:

Байгууллага бизнес болон захиргааны оролцогч талуудын ач холбогдлыг ойлгож эхэлж байгаа хэдий ч оролцогч талуудтай харилцах харилцаа тогтмол, системтэй бус, хангалттай үр дүнд хүрдэггүй байна. Санал хүсэлтийг цуглуулах оролдлого хийгддэг боловч үр дүнг нь бүрэн дүүрэн ашигладаггүй.

Баримтжуулалт:

Гээцөө эгч

Асуулт-46

Байгууллага бизнес эрхлэгчид, хувийн хэвшил, бусад захиргааны байгууллагуудтай харилцан ашигтай, үр дүнтэй түншлэл хөгжүүлж, хамтын ажиллагааг бэхжүүлэн, мэдээлэл солилцож, хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, нөөцийг хуваалцаж, инновацийг дэмжин, нийтлэг зорилгод хүрэхэд чиглэсэн хамтын ажиллагааг өргөжүүлдэг.

Хариулт:

Байгууллага нь бизнесийн болон захиргааны оролцогч талуудтай харилцан ашигтай түншлэл хөгжүүлэхэд анхаарч, түншлэлийн зорилго, хүрээг тодорхойлох ажлыг эхлүүлж, хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсруулж байна. Мөн мэдээлэл солилцоо болон хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд илүү системтэй хандлагыг нэвтрүүлж байгаа нь ажиглагдаж байна.

Баримтжуулалт:

Гээцөө эгч

Асуулт-47

Байгууллага бизнес эрхлэгчид, хувийн хэвшил, бусад захиргааны байгууллагуудтай тогтмол, нээлттэй, ил тод харилцаа холбоог дэмжиж, саналыг нь сонсож, мэдээлэл өгч, хүлээлтийг зохицуулж, асуудал, бэрхшээлийг шийдвэрлэж, харилцан итгэлцэл, ойлголцлыг бий болгодог.

Хариулт:

Байгууллага нь харилцагч талуудтай харилцах тодорхой процессуудыг бий болгож, тогтмол харилцааны сувгуудыг бүрдүүлсэн боловч харилцагч талуудын саналыг сонсож,

санаа зовнилыг шийдвэрлэхийг эрмэлздэг хэдий ч энэ нь бүрэн дүүрэн системтэй, идэвхтэй хэлбэрт шилжээгүй байна.

Баримтжуулалт:

Гээцоо эгч

Асуулт-48

Бизнес ба захиргааны оролцогчдоос ирсэн санал хүсэлтийг үнэлж, тэдэнд үзүүлж буй дэмжлэгийг тасралтгүй сайжруулж, хэрэгцээ, хүлээлтэд нийцүүлэн хөгжүүлж, түншлэлийг бэхжүүлж, урт хугацааны хамтын ажиллагааг дэмждэг.

Хариулт:

Байгууллага нь санал хүсэлтийг цуглуулах, дэмжлэгийг сайжруулах, түншлэлийг бэхжүүлэх, урт хугацааны хамтын ажиллагааг дэмжих зэрэг асуудлаар анхан шатны ойлголттой болж эхэлж байна. Оролцогч талуудаас санал хүсэлтийг хааяа цуглуулж, үнэлдэг боловч энэ нь тогтмол бус байна. Дэмжлэгийг сайжруулах чиглэлээр тодорхой оролдлогууд хийгдэж байгаа боловч системгүй, бүрэн хэрэгжилтгүй байна. Оролцогч талуудын хэрэгцээ, хүлээлтийг хангахад анхаарч эхэлж байгаа хэдий ч хангалттай түвшинд хүрээгүй байна.

Баримтжуулалт:

Гээцоо эгч

НИЙГЭМ – ХӨГЖИЛ, САЙН САЙХАН БАЙДАЛ, ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХУВЬ НЭМЭР ОРУУЛАХ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь нийгмийн хөгжил, сайн сайхан байдал, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахаас хамаардаг. Нийгмийн хөгжил нь иргэдийн амьдралын чанар, боловсрол, эрүүл мэнд, орлогын түвшинг сайжруулахад чиглэгддэг. Сайн сайхан байдал нь иргэдийн сэтгэл ханамж, аюулгүй байдал, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгддэг. Тогтвортой хөгжил нь байгаль орчин, эдийн засаг, нийгмийн тэнцвэрийг хангах замаар ирээдүйд тогтвортой амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгддэг.

Асуулт-49

Үндэсний хөгжлийн бодлого, нийгмийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, зорилтуудтай үйл ажиллагаагаа бүрэн уялдуулан, эдгээр зорилгод хувь нэмэр оруулахуйц үйл ажиллагааг хэрэгжүүлж, нийгмийн эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ тогтмол оруулдаг.

Хариулт:

Байгууллага нь үндэсний хөгжлийн бодлого, нийгмийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, зорилтуудыг сайтар ухамсарлан, үйл ажиллагаагаа тодорхой хэмжээнд уялдуулах системтэй арга барилтай болж байгаа нь ажиглагдаж байна. Мөн эдгээр зорилгод хувь нэмэр оруулах чиглэлээр төлөвлөгөөтэй ажиллаж, нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж байгаа хэдий ч сайжруулах нөөц боломж бүрэн дүүрэн ашиглагдаагүй байна.

Баримтжуулалт:

НХХ

Асуулт-50

Үйл ажиллагааныхаа үр дүн, нийгэмд оруулж буй хувь нэмрийн талаар олон нийтэд ил тод, ойлгомжтой мэдээлэл өгч, тогтмол тайлагнаж, иргэдийн хяналтыг хангаж, хариуцлагатай байдлыг бүрэн хэрэгжүүлдэг.

Хариулт:

Байгууллага нь нийгэмд оруулж буй хувь нэмрийн талаар тодорхой ойлголттой болж, ил тод мэдээлэх, тайлагнах, хариуцлагатай байхтай холбоотой тодорхой журмуудыг боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн хэдий ч иргэдийн хяналтыг хангах тогтмол тайлагнах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн тодорхой сувгуудыг ашиглаж эхэлсэн нь бүрэн дүүрэн бус байна.

Баримтжуулалт:

Цэнгэл эгч

Асуулт-51

Үйл ажиллагааныхаа хүрээнд нийгэм, эдийн засаг, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх, хүний эрхийг хамгаалах, нийгмийн шударга ёсыг бэхжүүлэх, ялгаварлан гадуурхлыг бууруулах, байгаль орчны тогтвортой байдлыг хангах, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлдэг.

Хариулт:

Байгууллага нь нийгмийн хариуцлагаа ухамсарлан, тодорхой төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулж эхэлж байгаа нь ажиглагдаж байна. Түүнчлэн, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн бодлого, стратеги боловсруулан, зарим үйл ажиллагааг системтэйгээр хэрэгжүүлж эхлээд байна. Гэсэн хэдий ч, эдгээр хүчин чармайлтууд нь байгууллагын бүх үйл ажиллагааг бүрэн хамруулахад хараахан хангалттай биш бөгөөд тогтвортой сайжруулалтын түвшин хүссэн хэмжээнд хүрээгүй байна.

Баримтжуулалт:

Одбаяр

Асуулт-52

Нийгмийн хөгжилд чиглэсэн инновацийг дэмжиж, хөгжүүлж, туршиж, хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож, бусад байгууллага, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшилтэй хамтран ажиллаж, нөөцийг нэгтгэж, мэдлэг, туршлагаа хуваалцдаг.

Хариулт:

Байгууллага нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах, нийгмийн инновацийг дэмжих нь байгууллагын стратегийн нэг хэсэг болж эхэлж байгаагийн зэрэгцээ нийгмийн инновацийг хөгжүүлэх, турших, хэрэгжүүлэхэд чиглэсэн тодорхой төлөвлөгөө, хөтөлбөрүүд боловсруулагдан хэрэгжиж байгаа бөгөөд үүнээс гадна бусад байгууллага, иргэний нийгэм, хувийн хэвшилтэй хамтран ажиллах хүрээгээ тэлж, харилцаагаа бэхжүүлж байна.

Баримтжуулалт:

НХХ

**ТҮНШҮҮД - ХАРИЛЦАГЧ - НИЙЛҮҮЛЭГЧИД ХАРИЛЦААГ БИЙ БОЛГОЖ,
ТОГТВОРТОЙ ҮНЭТ ЗҮЙЛИЙГ БИЙ БОЛГОХ**

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь түншүүд ба нийлүүлэгчидтэй харилцааг бий болгож, тогтвортой үнэт зүйлийг бий болгоход дэмжлэг үзүүлэх чадвараас хамаардаг. Түншүүд ба нийлүүлэгчид нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, тогтвортой байдалд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэдний дэмжлэг, хамтын ажиллагаа нь байгууллагын амжилт, үр дүнтэй байдалд шууд нөлөөлдөг.

Асуулт-53

Түншүүд, нийлүүлэгчдийг зөвхөн гэрээт харилцаатай оролцогчид бус, харин байгууллагын стратегийн түншүүд гэж үзэж, тэдэнтэй урт хугацааны, харилцан ашигтай, тогтвортой харилцааг бий болгож, хөгжүүлэхэд тогтмол анхаардаг.

Хариулт:

Байгууллага нь түншүүд болон нийлүүлэгчдийг өөрийн үйл ажиллагааны чухал оролцогч талууд хэмээн хүлээн зөвшөөрч, тэдэнтэй харилцах харилцааг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, журмыг боловсруулах ажлыг эхлүүлж байна. Харилцааны хүрээнд талуудын харилцан ашигтай байдлыг хангах зарчмыг баримтлан ажиллана. Мөн урт хугацааны харилцааны ач холбогдлыг гүн гүнзгий ойлгож, тодорхой төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулна.

Баримтжуулалт:

Гээцоо эгч

Асуулт-54

Түншүүд, нийлүүлэгчидтэй харилцахдаа харилцан ашигтай байдал, шударга ёс, ил тод байдлыг дээдэлж, гэрээ хэлцэл болон төлбөр тооцоог шударга, цаг тухайд нь хийж, харилцаанд ёс зүй, шударга байдлыг эрхэмлэдэг.

Хариулт:

Түншлэл болон нийлүүлэлтийн харилцааны чухлыг ухамсарлаж эхэлсэн хэдий ч харилцааг хөгжүүлэх, удирдах тогтолцоо хангалттай бүрэлдээгүй, харилцан ашигтай байдал, шударга ёс, ил тод байдлын талаарх ойлголттой боловч бодит хэрэгжилт хангалтгүй, гэрээ хэлцэл болон төлбөр тооцоог цаг тухайд нь гүйцэтгэхийг эрмэлздэг хэдий ч алдаа дутагдал гарч болзошгүй, ёс зүй, шударга ёсны зарчмыг бүрэн дүүрэн мөрддөггүй байна.

Баримтжуулалт:

Цэнгэл эгч

Асуулт-55

Түншүүд, нийлүүлэгчдийн хүчтэй сүлжээг бий болгож, тэдний хоорондын хамтын ажиллагааг дэмжиж, мэдлэг, туршлагаа хуваалцаж, инновацийн санааг дэмжиж, хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, үнэ цэнийн сүлжээг өргөжүүлж, хамтын ажиллагааны экосистемийг хөгжүүлдэг.

Хариулт:

Түнш болон нийлүүлэгчдийн хүчирхэг сүлжээг бүрдүүлэх, хамтын ажиллагааг идэвхжүүлэх, мэдлэг, туршлагаа хуваалцах, инновацийн санааг дэмжин хөгжүүлэх, хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, үнэ цэнийн сүлжээг өргөжүүлэн бэхжүүлэх, хамтын ажиллагааны экосистемийг хөгжүүлэх зэрэг чиглэлээр анхдагч ойлголт, санаачлагууд бий болж эхэлж байгаа нь ажиглагдаж байгаа хэдий ч эдгээр нь системтэй, төлөвлөгөөтэй хэлбэрт хараахан шилжээгүй байна.

Баримтжуулалт:

Гээцөө эгч

Асуулт-56

Түншүүд, нийлүүлэгчидтэй хамтын ажиллагааны үр дүнг тогтмол хянаж, үнэлж, тэдний гүйцэтгэлийг сайжруулах, харилцааг бэхжүүлэх, харилцан үр ашгийг нэмэгдүүлэх тасралтгүй үйл явцыг түншүүд, нийлүүлэгчдийн саналыг харгалзан хэрэгжүүлдэг.

Хариулт:

Тус байгууллага нь түншүүд болон нийлүүлэгчидтэй харилцах харилцааны чухлыг ухамсарлан ойлгож эхэлж, харилцааг сайжруулах, үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн анхан шатны ойлголттой болж, тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж буй хэдий ч харилцааг удирдах, хянах, сайжруулах тогтолцоо бүрэн дүүрэн бүрэлдэн бий болоогүй байна.

Баримтжуулалт:

Гээцөө эгч

ҮНЭ ЦЭНИЙГ ТОДОРХОЙЛЖ, БИЙ БОЛГОХ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь үнэ цэнийг тодорхойлж, бий болгох чадвараас хамаардаг. Үнэ цэнэ нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, иргэдийн сэтгэл ханамж, нийгмийн сайн сайхан байдалд шууд нөлөөлдөг.

Асуулт-57

Үйл ажиллагаагаа нийтийн үнэ цэнийг бий болгох, олон нийтийн сайн сайхны төлөө бүрэн чиглүүлж, нийгмийн сайн сайхан байдал, иргэдийн амьдралын чанар, эдийн засгийн өсөлт, байгаль орчны тогтвортой байдал зэрэг үнэ цэнийн гол шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлдог.

Хариулт:

Байгууллага нийтийн үнэ цэнийг бий болгох нь нэн чухал ач холбогдолтой гэдгийг хүлээн зөвшөөрч, үйл ажиллагаагаа тодорхой хэмжээгээр нийгмийн сайн сайхны төлөө чиглүүлэхээр зорьдог. Үнэ цэнийн гол шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлон хэмжих хүчин чармайлт гаргадаг боловч нийтийн үнэ цэнийг бүрэн дүүрэн бий болгож, тогтвортой байдлыг хангахуйц тогтолцоо хараахан бүрэлдэн тогтоогүй байна.

Баримтжуулалт:

Оюунбаатар

Асуулт-58

Иргэд, бизнес, бусад байгууллага зэрэг гол оролцогч талуудтай хамтран үнэ цэнийг бүтээх үйл явцыг хөгжүүлж, тэдний оролцоо, санал бодлыг харгалзан, хамтын ажиллагааг дэмжин, үнэ цэнийг хуваалцах механизмыг бий болгодог.

Хариулт:

Байгууллага нь оролцогч талуудыг татан оролцуулах, тэдэнтэй хамтран ажиллахын чухлыг ухамсарлан хүлээн зөвшөөрч, тодорхой хэмжээний үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлээд байна. Мөн үнэ цэнийг хамтран бүтээх асуудлыг тодорхой хэмжээнд ойлгож, зарим механизмыг бүрдүүлэх ажлыг эхлүүлж байна.

Баримтжуулалт:

Гээцоо эгч

Асуулт-59

Бий болгож буй үнэ цэнийг тодорхой шалгуур үзүүлэлтээр хэмжиж, үнэлж, үр дүнг олон нийтэд ил тод тайлагнаж, үнэ цэнийн бүтээлийг тасралтгүй сайжруулан нэмэгдүүлэх арга замыг тогтмол эрэлхийлдэг.

Хариулт:

Үнэ цэнийн ач холбогдлыг ухамсарлаж эхэлж буй хэдий ч тодорхойлох, хэмжих, үнэлэх, тайлагнах, сайжруулах тогтолцоо бүрэн дүүрэн хөгжөөгүй байна. Оролцогч талуудын хувьд үнэ цэнийг бий болгох хэрэгцээг хүлээн зөвшөөрч, тодорхой алхмуудыг хэрэгжүүлж эхэлсэн байна. Үнэ цэнийг хэмжих урьдчилсан оролдлогууд хийгдэж байгаа боловч эдгээр нь системгүй, нэг удаагийн шинж чанартай байна. Тайлагнах, сайжруулах үйл ажиллагаа бүрэн утгаараа хэрэгжиж эхлээгүй байна.

Баримтжуулалт:

Оюунбаатар

Асуулт-60

Үнэ цэнийг бий болгохдоо эдийн засаг, нийгэм, байгаль орчны тэнцвэрийг хангасан, урт хугацааны, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан, ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх үнэ цэнийг бүтээдэг.

Хариулт:

Байгууллага нь үнэ цэнийг тодорхойлон бий болгохдоо эдийн засаг, нийгэм, байгаль орчны тэнцвэрт байдлыг хангахыг эрмэлздэг бөгөөд урт хугацааны, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг тодорхой хэмжээнд ойлгож, үйл ажиллагаандаа тусгахыг хичээдэг хэдий ч үнэ цэнийг бий болгох нь байгууллагын соёл, үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг болж төлөвшөөгүй байна.

Баримтжуулалт:

Одбаяр

ҮНЭ ЦЭНИЙГ ОЙЛГОЖ, ОЛОН НИЙТЭД ТАНИУЛАХ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь үнэ цэнийг ойлгож, олон нийтэд таниулах чадвараас хамаардаг. Үнэ цэнийг ойлгож, хүлээн зөвшөөрөх нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, иргэдийн сэтгэл ханамж, нийгмийн сайн сайхан байдалд чухал ач холбогдолтой.

Асуулт-61

Бий болгож буй нийтийн үнэ цэнийг (үйлчилгээний чанар, хэмнэлт, шуурхай байдал, нийгмийн эерэг нөлөө, байгаль орчинд ээлтэй байдал ...) бий болгож, хөгжүүлдэг.

Хариулт:

Байгууллага нийтийн үнэ цэнийг тодорхойлох, ойлгох түвшинд ахиц гаргаж эхэлсэн хэдий ч нийтийн үнэ цэнийг бий болгох зорилготой зарим үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж байгаа нь харагдаж байгаа боловч эдгээр нь бүрэн дүүрэн бус, уялдаа холбоо хангалтгүй байна. Түүнчлэн үйлчилгээний чанар, хэмнэлт, шуурхай байдал, нийгмийн эерэг нөлөө,

байгаль орчинд ээлтэй байдлыг дээшлүүлэхэд тодорхой анхаарал хандуулж эхэлж байгаа хэдий ч системтэй арга барил хараахан төлөвшөөгүй байна.

Баримтжуулалт:

Одбаяр

Асуулт-62

Байгууллага тодорхойлсон нийтийн үнэ цэнээ олон нийтэд үр дүнтэй арга хэрэгслээр сурталчилж, түгээн дэлгэрүүлэн, олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлж, байгууллагад итгэх итгэлийг бэхжүүлдэг.

Хариулт:

Байгууллага нийтийн үнэ цэнийн талаарх ойлголттой болж эхэлж байгаа хэдий ч сурталчилгааны үйл ажиллагаа хангалтгүй бөгөөд ихэвчлэн хариу үйлдэл үзүүлэх хэлбэртэй байна. Мөн нийтийн үнэ цэнээ тодорхойлсон боловч олон нийтэд идэвхтэй сурталчлах тал дээр хангалттай анхаарал хандуулдаггүй. Харилцаа холбооны үйл ажиллагаа нь гаднын шаардлага, нөхцөл байдлын дагуу хэрэгждэг.

Баримтжуулалт:

Батболд ах

Асуулт-63

Байгууллага үнэ цэнийн талаарх ойлголтоо гол оролцогч талуудтай харилцан ярилцаж, хэлэлцүүлэг өрнүүлэн, санал бодлыг нь сонсож, харилцан ойлголцож, үнэ цэнийн талаарх нэгдмэл ойлголтод хүрдэг.

Хариулт:

Байгууллага нь оролцогч талуудын ач холбогдлыг хүлээн зөвшөөрдөг хэдий ч үнэ цэнийн талаарх ойлголтоо тэдэнтэй хуваалцаж, харилцан яриа өрнүүлэх нь зүйтэй гэсэн хандлага хараахан төлөвшөөгүй байна. Түүнчлэн, оролцогч талуудтай харилцаа холбоо тогтоох тохиолдол үе үе ажиглагдах боловч энэ нь системгүй, харилцан ойлголцолд хүрэх зорилгогүй, нэг талыг баримталсан хандлагатай байдаг.

Баримтжуулалт:

Оюунбаатар

Асуулт-64

Байгууллага үнэ цэнийг таниулах үйл явцын үр дүнг тогтмол хянаж, үнэлж, ажилтнуудын санал бодлыг сонсон, сургамж авч, үнэ цэнийг таниулах арга хэрэгслээ тасралтгүй сайжруулж, нийгмийн өөрчлөлт, харилцаа холбооны шинэ сувгуудад цаг тухайд нь дасан зохицдог.

Хариулт:

Байгууллага үнэ цэнийг таниулахын чухлыг ухамсарлан, энэ чиглэлд тодорхой алхмуудыг хэрэгжүүлж эхэлж байгаа боловч үйл явц нь системгүй, хааяа нэг удаагийн арга хэмжээний шинжтэй байна. Мөн үр дүнгийн хяналт, үнэлгээ хангалтгүй, ажилтнуудын саналыг хааяа сонсдог ч системтэй хэлбэрт шилжээгүй байна.

Баримтжуулалт:

Золоо

ҮНЭ ЦЭНИЙГ ХҮРГЭХ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь үнэ цэнийг хүргэх чадвараас хамаардаг. Үнэ цэнийг хүргэх нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, иргэдийн сэтгэл ханамж, нийгмийн сайн сайхан байдалд чухал ач холбогдолтой.

Асуулт-65

Үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлж, нөөцийг оновчтой ашиглаж, бүтээмжийг нэмэгдүүлэх замаар үнэ цэнийг үр дүнтэй, хэмнэлттэй аргаар хүргэж, зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлдэг.

Хариулт:

Процессийн эхлэл буюу үндсэн процессууд. Байгууллага нь үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, нөөцийг оновчтой ашиглах, бүтээмжийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байгааг ухамсарлан ойлгож эхэлж байгаагийн зэрэгцээ зарим үндсэн процессууд бүрэлдэн бий болж эхэлж байгаа боловч эдгээр нь бүрэн дүүрэн хэрэгжиж, үр дүнгээ өгч амжаагүй байна.

Баримтжуулалт:

Одбаяр

Асуулт-66

Хэрэглэгчдэд ээлтэй, тохиромжтой, хүндрэлгүй, шуурхай, үр дүнтэй аргаар иргэдэд үйлчилгээг хүргэж, үйлчилгээний хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлдэг.

Хариулт:

Үйлчилгээ үзүүлэх үйл явц тодорхой болж, мэргэжлийн түвшинд хүрч сайжирч, чанарын баталгааг хангах эхлэл тавигдаж байна. Түүнчлэн иргэдэд ээлтэй, тохиромжтой, хүндрэл чирэгдэлгүй, шуурхай байдлыг хангах стандарт, журмыг боловсруулан хэрэгжүүлж байна. Үйлчилгээний хүртээмжтэй байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн тодорхой зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжилтийг хангаж байна. Иргэдээс тогтмол санал хүсэлтийг хүлээн авч, үйлчилгээндээ тусган хэрэгжүүлж байна.

Баримтжуулалт:

Гээцоо эгч

Асуулт-67

Үйлчилгээний хүртээмжтэй байдал, тэгш байдлыг хангаж, үйлчилгээг бүх иргэдэд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан, ядуу эмзэг бүлгийн иргэдэд хүндрэлгүй, тэгш хүртээмжтэй хүргэж, ялгаварлан гадуурхлыг бууруулдаг.

Хариулт:

Байгууллага нь үйл ажиллагааны процессуудыг системтэй үнэлж сайжруулахын зэрэгцээ хүртээмжтэй байдал, тэгш байдлыг хангах бодлого, журмыг бүхий л үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, эмзэг бүлгийн иргэдийн санал хүсэлтийг тогтмол авч үйлчилгээгээ сайжруулж, ялгаварлан гадуурхлыг бууруулахад идэвхтэй ажилладаг.

Баримтжуулалт:

НХХ

Асуулт-68

Үйлчилгээний хүргэлтийн үр дүнг тогтмол хянаж, үнэлж, иргэдийн санал бодлыг сонсож, сургамж авч, хүргэлтийн арга барил, процессыг тасралтгүй сайжруулах, үр дүнг нэмэгдүүлэх арга замыг тогтмол эрэлхийлдэг.

Хариулт:

Байгууллага нь үйлчилгээний хүргэлтийн үр дүнд тогтмол хяналт, үнэлгээ хийх бүрэн төлөвшсөн системтэй бөгөөд иргэдийн санал бодлыг сонсох олон төрлийн арга хэрэгслийг ашиглан, үр дүнг нь сайжруулалтын процесст идэвхтэй ашигладаг. Сургамж авах, сайжруулалт хийх нь байгууллагын соёлын нэг хэсэг болохын зэрэгцээ хүргэлтийн арга барил, процессыг тасралтгүй сайжруулах, үр дүнг нэмэгдүүлэхэд чиглэсэн тодорхой сайжруулалтын төслүүдийг хэрэгжүүлдэг.

Баримтжуулалт:

Гээцоо эгч

НИЙТ ТУРШЛАГЫГ ТОДОРХОЙЛЖ, АШИГЛАДАГ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь нийт туршлагыг тодорхойлж, ашиглах чадвараас хамаардаг. Нийт туршлага нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, иргэдийн сэтгэл ханамж, нийгмийн сайн сайхан байдалд чухал ач холбогдолтой.

Асуулт-69

Иргэд, ажилтнууд, түншүүд, нийлүүлэгчид болон бусад гол оролцогч талуудын байгууллагатай харилцах бүхий л үе шат, бүхий л харилцааны цогц туршлагыг бүрэн дүүрэн ойлгож, эдгээр туршлагыг сайжруулах цогц төлөвлөгөөг хэрэгжүүлдэг.

Хариулт:

Байгууллага нь оролцогч талуудын туршлагын ач холбогдлыг ухамсарлан ойлгож эхэлж байгаа төдийгүй, туршлагатай холбоотой мэдээлэл цуглуулах, харилцаа холбоо тогтоох үндсэн арга хэрэгслүүдийг нэвтрүүлж эхэлсэн байна. Гэсэн хэдий ч эдгээр нь системтэй, төлөвлөгөөтэй бус, харин хариу арга хэмжээний шинжтэй байна.

Баримтжуулалт:

Гээцоо эгч

Асуулт-70

Нийт туршлагаа хэрэглэгч төвтэй байдлаар тодорхойлж, хэрэгцээ, хүлээлтэд нийцсэн, хувьчилсан, хэрэглэгчдэд ээлтэй, хүндрэлгүй, тохиромжтой туршлагыг бүрэн дүүрэн бүрдүүлдэг.

Хариулт:

Байгууллага хэрэглэгчийн туршлагын ач холбогдлыг анхлан ойлгож эхэлж байгаа хэдий ч тэдгээрийн хүчин чармайлтууд нь системгүй, түр зуурын шинжтэй байхын зэрэгцээ хэрэглэгчдийн үндсэн санал хүсэлтийг цуглуулах зэрэг үйл ажиллагааг хааяа зохион байгуулдаг бөгөөд энэ нь хэрэглэгч төвтэй байдлын суурь ойлголттой болохын эхлэл гэж үзэж болно.

Баримтжуулалт:

Одбаяр

Асуулт-71

Нийт туршлагыг хэрэгжүүлэхдээ ажилтнуудын эерэг сэтгэл хөдлөл, хүнлэг хандлагыг төлөвшүүлж, оролцогч талуудтай харилцахдаа хүндэтгэлтэй, эелдэг, анхааралтай, эмзэглэлтэй хандах соёлыг бүрэн дүүрэн бий болгодог.

Хариулт:

Байгууллага эерэг харилцааны ач холбогдлыг ухамсарлан ойлгож эхэлсэн хэдий ч албан ёсны бодлого, журам боловсруулагдаагүй байна. Үүнээс шалтгаалан зарим ажилтнуудын санаачилга ажиглагдаж байгаа хэдий ч байгууллагын хүрээнд системтэй хэрэгжилт хангагдахгүй байна.

Баримтжуулалт:

Золоо

Асуулт-72

Байгууллага нийт туршлагын үр дүнг тодорхой шалгуур үзүүлэлтээр хэмжиж, үнэлж, иргэд болон бусад оролцогч талуудын санал бодлыг сонсон, сургамж авч, нийт туршлагыг тасралтгүй сайжруулан хөгжүүлэх арга замыг байнга эрэлхийлдэг.

Хариулт:

Байгууллага нийт туршлагын ач холбогдлыг ухамсарлан ойлгож эхэлж байгаа хэдий ч уг туршлагыг тодорхойлох, хэмжих, үнэлэх арга зүй хараахан бүрэн төлөвшөөгүй байна. Оролцогч талуудын санал бодлыг хааяа сонсдог боловч энэ нь тогтолцоотой, системтэй хэлбэрт шилжээгүй байна. Сургамж авах, үйл ажиллагааг сайжруулах чиглэлд тодорхой оролдлогууд гаргадаг хэдий ч эдгээр нь тогтмол, системтэй хэрэгждэггүй байна.

Баримтжуулалт:

Одбаяр

ГҮЙЦЭТГЭЛИЙГ УДИРДДАГ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь гүйцэтгэлийг удирдах чадвараас хамаардаг. Гүйцэтгэлийг удирдах нь байгууллагын зорилго, стратегийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө, хяналт, үнэлгээний систем юм.

Асуулт-73

Гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог байгууллагын стратеги, зорилготой бүрэн уялдуулж, үйл ажиллагааг нийтийн үнэ цэнийг бий болгох, иргэдэд үйлчлэх гол зорилгод бүрэн чиглүүлэн удирдан хэрэгжүүлдэг.

Хариулт:

Гүйцэтгэлийн удирдлагын суурь тогтолцоо бүрэлдэн тогтох эхний шатандаа явж байгаагийн хувьд байгууллагын удирдлагаас тодорхойлсон стратеги, зорилтууд нь ажилтнуудад хангалттай хэмжээнд ойлгогдоогүйгээс үйл ажиллагаанд шууд нөлөөлөхүйц тодорхой бус байдалтай байна. Мөн гүйцэтгэлийг хянан сайжруулах үйл явцыг дэмжих зорилготой журам, зааварчилгааны баримт бичгүүд хангалтгүй хэмжээнд боловсруулагдсан байна.

Баримтжуулалт:

Оюунбаатар

Асуулт-74

Гүйцэтгэлийн удирдлагыг тасралтгүй сайжруулалт, суралцахуйн соёлд тулгуурлан хөгжүүлж, гүйцэтгэлийг хянаж, үнэлэх, сургамж авах, шинэ арга барилыг турших, үр дүнг сайжруулах, өөрчлөлтөд дасан зохицох чадварыг дээшлүүлэхэд бүрэн чиглүүлдэг.

Хариулт:

Гүйцэтгэлийн удирдлагын үндсэн ойлголттой болж эхэлж байгаа боловч системтэй хэрэгждэггүй. Тасралтгүй сайжруулалт, суралцахуйн соёлын эхлэл тавигдаж байгаа боловч хараахан төлөвшөөгүй. Гүйцэтгэлийг хянах, үнэлэх анхны оролдлогууд хийгдэж байгаа ч үр дүн багатай. Өөрчлөлтөд дасан зохицох чадавх хязгаарлагдмал.

Баримтжуулалт:

Оюунбаатар

Асуулт-75

Бодит мэдээлэл, тоон үзүүлэлт, судалгаанд үндэслэсэн гүйцэтгэлийн удирдлагын аргачлалыг хэрэгжүүлж, цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийн, сургамж авч, шийдвэр гаргалт болон үйл ажиллагааг сайжруулахад ашигладаг.

Хариулт:

Байгууллага гүйцэтгэлийг удирдах үйл явцдаа бодит мэдээлэл, тоон үзүүлэлтийн ач холбогдлыг аажмаар ойлгож эхэлж байгаа хэдий ч мэдээлэл цуглуулах, шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа хийх нь хараахан тогтолцоотой болоогүй, эмх замбараагүй байдлаар хэрэгждэг бөгөөд шийдвэр гаргалт болон сайжруулалтын үйл ажиллагаанд мэдээллийг хязгаарлагдмал хүрээнд ашиглаж байна.

Баримтжуулалт:

Оюунбаатар

Асуулт-76

Хариуцлагатай, ил тод байдлыг хангахуйц гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнгийн талаар олон нийтэд ил тод мэдээлж, тайлагнадаг.

Хариулт:

Гүйцэтгэлийн удирдлагын үндсэн ойлголт, хэрэгцээ бий болж эхэлсэн. Гүйцэтгэлийг хэмжих, үнэлэх анхны оролдлогууд хийгдэж байгаа боловч хариуцлага, ил тод байдал бүрэн хангагдаагүй, олон нийтэд мэдээлэх, тайлагнах үйл ажиллагаа хангалтгүй.

Баримтжуулалт:

Оюунбаатар

БАЙГУУЛЛАГЫН ИРЭЭДҮЙД ӨӨРЧИЛӨЛТИЙГ УДИРДАХ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь байгууллагыг ирээдүйд өөрчлөх чадвараас хамаардаг. Байгууллагыг ирээдүйд өөрчлөх нь байгууллагын зорилго, стратегийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө, хяналт, үнэлгээний систем юм.

Асуулт-77

Ирээдүйн чиг хандлага, өөрчлөлтийг урьдчилан харж, тодорхойлж, байгууллагыг ирээдүйд чиглүүлсэн алсын харааг бий болгож, идэвхтэй өөрчлөлтийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлдэг.

Хариулт:

Байгууллага ирээдүйн чиг хандлага, өөрчлөлтийг тодорхойлох, алсын хараа бий болгох, өөрчлөлтийн төлөвлөгөө боловсруулах талаар тодорхой арга барил, ойлголттой болж эхэлж байна. Алсын хараа нь байгууллагын стратегийн зорилтуудтай уялдан тодорхойлогдож, өөрчлөлтийн төлөвлөгөө нь үндсэн үйл ажиллагаатай уялдуулан боловсруулагдаж, хэрэгжиж эхэлж байна.

Баримтжуулалт:

Одбаяр

Асуулт-78

Ирээдүйн өөрчлөлтийг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ ажилтнууд болон гол оролцогч талуудыг идэвхтэй оролцуулж, санал бодлыг нь харгалзан үздэг.

Хариулт:

Өөрчлөлтийг удирдах тодорхой арга зүй, процессууд бүрдэж эхэлсэн. Ажилтнууд болон гол оролцогч талуудыг өөрчлөлтийн талаар мэдээлж, санал бодлыг нь цуглуулах механизмыг бүрдүүлсэн. Санал бодлыг шийдвэр гаргахдаа харгалзан үздэг боловч, бүрэн дүүрэн тусгадаггүй.

Баримтжуулалт:

Одбаяр

Асуулт-79

Хэрэгжүүлж буй өөрчлөлтийн үр дүнг тодорхой шалгуур үзүүлэлтээр хэмжиж, үнэлж, сургамж авч, цаашдын өөрчлөлтийг илүү үр дүнтэй, амжилттай болгох, байгууллагын өөрчлөлтийг удирдах чадавхийг тасралтгүй сайжруулдаг.

Хариулт:

Өөрчлөлтийг удирдах суурь ойлголттой болж, зарим тохиолдолд төлөвлөгөө боловсруулж эхэлдэг. Гэсэн хэдий ч өөрчлөлтийг хэмжих, үнэлэх шалгуур үзүүлэлт тодорхойгүй, үр дүнг системтэйгээр хянаж, үнэлдэггүй. Сургамж авах, сайжруулахад анхаарч эхэлдэг боловч тогтмол бус.

Баримтжуулалт:

Одбаяр

Асуулт-80

Өөрчлөлтөд дасан зохицох чадвартай, уян хатан байгууллагын соёлыг төлөвшүүлж, ажилтнуудыг өөрчлөлтөд нээлттэй хандах, шинэ зүйлийг турших, санаачилга гаргах, хамтран ажиллах, тасралтгүй суралцах, өөрчлөлтөд хурдан дасан зохицох чадварыг дээшлүүлдэг.

Хариулт:

Байгууллага өөрчлөлтийн шаардлагатайг хүлээн зөвшөөрч эхэлж байгаа боловч соёлын хувьд идэвхгүй, болгоомжтой ханддаг. Ажилтнууд шинэ зүйлийг туршихаас эмээдэг,

санаачилга гаргах нь хязгаарлагдмал. Хамтын ажиллагаа хангалтгүй, суралцах нь албан бус хэлбэрээр явагддаг. Өөрчлөлтөд дасан зохицох хурд удаан.

Баримтжуулалт:

Золоо

ИННОВАЦИ БА ТЕХНОЛОГИЙГ УДИРДАХ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь инноваци ба технологийг удирдах чадвараас хамаардаг. Инноваци нь шинэ санаа, шийдлийг гаргаж ирэх чадвар бөгөөд технологи нь эдгээр санааг бодит үйл ажиллагаанд хэрэгжүүлэх хэрэгсэл юм.

Асуулт-81

Инноваци, технологийн хөгжлийг байгууллагын стратеги, зорилгод нийцүүлэн, нийтийн үнэ цэнийг бий болгох, иргэдэд үйлчлэх зорилгод бүрэн чиглүүлэн төлөвлөж, хэрэгжүүлдэг.

Хариулт:

Инноваци, технологийн хөгжилд системтэй хандлага байхгүй. Салангид, тохиолдлын шинжтэй, хувь хүний санаачилгад тулгуурласан үйл ажиллагаа явагддаг. Байгууллагын стратеги, зорилгод нийцээгүй, нийтийн үнэ цэн, иргэдэд үйлчлэх зорилгыг хангалттай тусгаагүй байна.

Баримтжуулалт:

Одбаяр

Асуулт-82

Ажилтнуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлж, инновацийн санааг дэмжин, туршилт хийж, эрсдэл хүлээхээс айхгүй байх, тасралтгүй суралцах, технологийн шинэ шийдлийг эрэлхийлэн, нэвтрүүлэхэд бэлэн байх байгууллагын соёлыг төлөвшүүлж, технологийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд тогтмол хөрөнгө оруулалт хийдэг.

Хариулт:

Инноваци, технологийн асуудалд хандах албан ёсны арга барил байхгүй, эсвэл хангалтгүй. Бүтээлч санаачлага хувь хүний хүсэл зоригоос шалтгаалж, дэмжлэг хомс, технологийн шинэчлэл хайхрагдахгүй, эрсдэлээс зайлсхийх хандлага давамгайлна. Байгууллагын соёл нь инноваци, технологийн хөгжлийг дэмжихгүй, технологийн ур чадварыг дээшлүүлэх хөрөнгө оруулалт хийгдэхгүй.

Баримтжуулалт:

Одбаяр

Асуулт-83

Цахим технологийн дэвшлийг үр ашигтай ашиглаж, үйлчилгээг цахимжуулах, процессыг автоматжуулах, мэдээллийг үр дүнтэй ашиглах, шийдвэр гаргалтыг сайжруулах, цахим шилжилтийг хурдасгаж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлдэг.

Хариулт:

Цахим технологийн дэвшлийг ашиглах, инноваци нэвтрүүлэх эхний алхмууд хийгдэж байна. Зарим үйлчилгээг цахимжуулах, процессыг автоматжуулах туршилтууд хийгдэж байгаа боловч эдгээр нь системтэй, байгууллагын хэмжээний бодлоготой уялдаагүй

байна. Мэдээллийг ашиглах, шийдвэр гаргалтыг сайжруулах, цахим шилжилтийг хурдасгах, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ойлголт дөнгөж бүрэлдэж эхэлж байна.

Баримтжуулалт:

Батболд

Асуулт-84

Инноваци, технологийн хөгжлийг удирдахдаа эрсдэлийг сайтар тооцож, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, ёс зүйн хэм хэмжээг баримталж, технологийн хэрэглээний ёс зүйн асуудлыг харгалзан үздэг.

Хариулт:

Байгууллага инноваци, технологийн хөгжилд эрсдэл, ёс зүйн асуудлын ач холбогдлыг ойлгож эхэлж байна. Гэхдээ системтэй арга барил хараахан бий болоогүй. Зарим удирдамж, журам байж болох ч, тогтмол хэрэгждэггүй, хяналт сул.

Баримтжуулалт:

Батболд

ӨГӨГДӨЛД СУУРИЛСАН ОЙЛГОЛТ БА МЭДЛЭГИЙГ АШИГЛАДАГ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь өгөгдөлд суурилсан ойлголт ба мэдлэгийг ашиглах чадвараас хамаардаг. Өгөгдөлд суурилсан ойлголт нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, иргэдийн сэтгэл ханамж, нийгмийн сайн сайхан байдалд чухал ач холбогдолтой.

Асуулт-85

Стратеги, бодлогын шийдвэр гаргахдаа бодит өгөгдөл, судалгаа шинжилгээнд үндэслэн, шийдвэр бүрийг нотолгоо, баримтаар баталгаажуулан гаргадаг.

Хариулт:

Өгөгдлийн ач холбогдлыг ойлгож, зарим өгөгдлийг цуглуулж эхэлсэн. Гэхдээ өгөгдлийг шийдвэр гаргахад системтэйгээр ашигладаггүй, шинжилгээ хийх нь хязгаарлагдмал.

Баримтжуулалт:

Одбаяр

Асуулт-86

Үйл ажиллагааны гүйцэтгэлийг хэмжих, үнэлэх, сайжруулах, ахиц дэвшлийг хянах, үр дүнг тооцоолох, тайлагнахдаа өгөгдлийг гол хэрэгсэл болгон бүрэн ашигладаг.

Хариулт:

Байгууллагад өгөгдлийн ач холбогдлыг ойлгож эхэлж байгаа боловч өгөгдлийг цуглуулах, ашиглах нь системгүй, хязгаарлагдмал хүрээнд явагддаг. Гүйцэтгэлийг хэмжих, үнэлэхэд зарим төрлийн өгөгдлийг ашигладаг боловч, сайжруулалт, ахиц дэвшлийн хяналт, үр дүнгийн тооцоололд өгөгдлийн ашиглалт хангалтгүй.

Баримтжуулалт:

Одбаяр

Асуулт-87

Иргэдийн хэрэгцээ, хүлээлтийг гүнзгий ойлгож, тэдэнд нийцсэн үйлчилгээг үзүүлэх, сайжруулахын тулд иргэдийн санал хүсэлт, хэрэглэгчийн мэдээлэл, судалгааны өгөгдлийг тогтмол цуглуулж, дүн шинжилгээ хийж, үйлчилгээний төлөвлөлт, хүргэлт, сайжруулалтад бүрэн ашигладаг.

Хариулт:

Иргэдийн хэрэгцээ, хүлээлтийг ойлгох, тэдэнд нийцсэн үйлчилгээ үзүүлэхэд өгөгдөл ашиглах эхний алхмууд хийгдэж байна. Санал хүсэлтийг хааяа цуглуулж, тоймлон хардаг боловч, системтэй дүн шинжилгээ хийж, үйлчилгээнд тусгах нь хангалтгүй.

Баримтжуулалт:

Гээцоо эгч

Асуулт-88

Өгөгдөлд суурилсан мэдлэг, ойлголтыг байгууллагын хэмжээнд хуваалцаж, ажилтнуудын мэдлэг, чадавхийг дээшлүүлж, байгууллагын суралцах чадварыг нэмэгдүүлж, инновацийн үйл ажиллагааг дэмжиж, байгууллага даяар мэдлэгт суурилсан соёлыг төлөвшүүлэхэд өгөгдлийг үр ашигтай ашигладаг.

Хариулт:

Байгууллагад тодорхой хэмжээнд өгөгдөл цуглуулж эхэлсэн боловч, ашиглалт нь хязгаарлагдмал, системгүй. Өгөгдлийг голчлон тайлагнах зорилгоор ашигладаг. Өгөгдөлд суурилсан мэдлэгийг хэсэгчлэн хуваалцаж, ажилтнуудын чадавхийг хэсэгчлэн дээшлүүлэх оролдлого хийгддэг. Суралцах байгууллага болох, инновацийг дэмжих, мэдлэгт суурилсан соёлыг төлөвшүүлэх эхлэл тавигдаж байна.

Баримтжуулалт:

Одбаяр

ХӨРӨНГӨ БА НӨӨЦИЙГ УДИРДАХ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь хөрөнгө ба нөөцийг удирдах чадвараас хамаардаг. Хөрөнгө ба нөөцийг үр ашигтай удирдах нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, тогтвортой байдалд чухал ач холбогдолтой.

Асуулт-89

Санхүүгийн, хүний, технологийн, мэдээллийн болон бусад хөрөнгө, нөөцийг байгууллагын стратеги, зорилгод нийцүүлэн, нийтийн үнэ цэнийг бий болгох, иргэдэд үйлчлэх гол зорилгод чиглүүлэн төлөвлөж, оновчтой хуваарилж, үр ашигтай, хэмнэлттэй ашигладаг.

Хариулт:

Хөрөнгө, нөөцийг удирдах тодорхой журам, үйл явц бий болсон. Төлөвлөлт, хуваарилалт нь байгууллагын стратеги, зорилгод нийцсэн, тогтмол хэрэгждэг. Үр ашиг, хэмнэлтийг сайжруулах чиглэлээр идэвхтэй ажиллаж байна. Нийтийн үнэ цэнэ, иргэдэд үйлчлэх зорилгыг хангахад чиглэсэн үйл ажиллагаанууд хэрэгжиж байна.

Баримтжуулалт:

Сувдаа эгч

Асуулт-90

Хөрөнгө, нөөцийн ашиглалт, хуваарилалтыг тогтмол хянаж, үр ашгийг үнэлж, хэмнэлт гаргах боломжийг эрэлхийлж, нөөцийн үр ашгийг дээшлүүлэх арга замыг тодорхойлж, нөөцийн удирдлагын үр дүнг сайжруулдаг.

Хариулт:

Хөрөнгө, нөөцийн удирдлагын үндсэн ойлголттой болж эхэлж байгаа боловч, ашиглалт, хуваарилалт хангалттай хяналтад байдаггүй. Үр ашгийг хэмжих оролдлого хийгддэг боловч тогтмол биш. Нөөцийн үр ашгийг дээшлүүлэх талаар хааяа арга хэмжээ авдаг.

Баримтжуулалт:

Сувдаа эгч

Асуулт-91

Хөрөнгө, нөөцийг удирдахдаа тогтвортой байдал, байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагатай байх зарчмыг баримтлан, ёс зүйтэй, шударга, ил тод, хариуцлагатай удирдаж, ирээдүй хойч үедээ өвлүүлэх үнэ цэнийг хадгалах, нэмэгдүүлэхэд бүрэн чиглүүлдэг.

Хариулт:

Хөрөнгө, нөөцийн удирдлагын тодорхой арга барил, журам, зааварчилгаа боловсруулагдан хэрэгжиж эхэлсэн. Тогтвортой байдал, байгаль орчин, нийгмийн хариуцлагын асуудлыг байгууллагын үйл ажиллагаанд уялдуулан хэрэгжүүлэх оролдлого хийгдэж байна. Ёс зүй, шударга ёс, ил тод байдал, хариуцлагатай байдлын зарчмыг байгууллагын соёл болгон төлөвшүүлэх чиглэлд ажиллаж байна. Ирээдүй хойч үед өвлүүлэх үнэ цэнийг хадгалах, нэмэгдүүлэхэд чиглэсэн тодорхой зорилтууд дэвшүүлэн ажиллаж байна.

Баримтжуулалт:

Сувдаа эгч

Асуулт-92

Хөрөнгө, нөөцийг оновчтой ашиглах, үр ашгийг дээшлүүлэх, хэмнэлт гаргах, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн инноваци, технологийг эрэлхийлж, нэвтрүүлж, ашигладаг.

Хариулт:

Байгууллага хөрөнгө, нөөцийг удирдах тодорхой процессууд бий болж, үйл ажиллагааг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр технологи, инновацийг ашиглаж эхэлж байна. Гэсэн хэдий ч, эдгээр нь хараахан бүрэн төлөвшөөгүй, системтэй хяналт, сайжруулалт хийгддэггүй. Хэмнэлт гаргах, үйл ажиллагааг оновчтой болгох боломжуудыг тодорхойлж байгаа ч хараахан бүрэн дүүрэн хэрэгжүүлж чадахгүй байна.

Баримтжуулалт:

Сувдаа эгч

ИРГЭДИЙН ОЙЛГОЛТ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь иргэдийн ойлголтоос ихээхэн хамааралтай байдаг. Иргэдийн ойлголт нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, иргэдийн сэтгэл ханамж, нийгмийн сайн сайхан байдалд чухал ач холбогдолтой.

Асуулт-93

Иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх сэтгэл ханамж, итгэл, хүртээмж, чанар, үр дүн зэрэг ойлголтыг системтэйгээр, тогтмол хугацаанд цуглуулж, цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ойлголтыг тодорхойлдог.

Хариулт:

Байгууллага иргэдийн саналыг авах шаардлагатай гэдгийг ухамсарлаж эхэлж байгаа боловч энэ нь тогтолцоогүй, харин хааяа нэг удаа санал асуулга зохион байгуулах хэлбэрээр хэрэгждэг. Цуглуулсан мэдээлэлд хангалттай дүн шинжилгээ хийгддэггүй, эсвэл огт хийгддэггүй бөгөөд улмаар иргэдийн санал хүсэлтийг байгууллагын үйл ажиллагаанд тусгах асуудал хараахан шийдвэрлэгдээгүй байна.

Баримтжуулалт:

Гээцөө эгч

Асуулт-94

Байгууллага иргэдийн ойлголтын үр дүнг зөвхөн хэмжилт, үнэлгээнд ашиглаад зогсохгүй, үйл ажиллагаагаа сайжруулах, үйлчилгээг иргэдэд ээлтэй болгох, инноваци нэвтрүүлэх, өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд идэвхтэй ашигладаг.

Хариулт:

Байгууллага иргэдийн ойлголтыг үндсэн хэмжилт болгон авч үзэж, цуглуулах үйл ажиллагааг эхлүүлсэн боловч цуглуулсан мэдээллийг голчлон тайлагнах зорилгоор ашигладаг бөгөөд шинжилгээний түвшин нь өнгөц байхаас гадна иргэдийн саналыг сайжруулах үйл ажиллагаанд идэвхтэй ашигладаггүй.

Баримтжуулалт:

Гээцөө эгч

Асуулт-95

Байгууллага иргэдийн ойлголтыг хэмжихдээ үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүн, хариуцлагатай байдал, ил тод байдал, шударга ёс, инноваци зэрэг төрийн үйлчилгээний гол үзүүлэлтүүдийг харгалзан, эдгээр үзүүлэлтээр иргэдийн ойлголтын түвшинг тогтмол үнэлдэг.

Хариулт:

Байгууллага нь иргэдийн ойлголтын талаар анхдагч ойлголттой болж, холбогдох хэмжилтийг эхлүүлэхээр төлөвлөж байгаа боловч төрийн үйлчилгээний үндсэн үзүүлэлтүүдийг хангалттай бус харгалзан, эсхүл огт харгалзахгүйгээр хэмжилт хийдэг. Мөн иргэдийн санал бодлыг цуглуулах арга хэрэгслийг (тухайлбал, хааяа зохион байгуулдаг санал асуулгыг) хэрэглэж эхэлсэн хэдий ч цуглуулсан мэдээлэлд системтэй дүн шинжилгээ хийж, үр дүнг үйл ажиллагаандаа тусгадаггүй байна.

Баримтжуулалт:

Гээцөө эгч

Асуулт-96

Байгууллага цуглуулсан иргэдийн ойлголтын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, иргэдийн ойлголтын өөрчлөлтийн чиг хандлагыг тодорхойлж, эерэг болон сөрөг чиг хандлагын шалтгааныг тогтмол судалдаг.

Хариулт:

Байгууллага иргэдийн ойлголтын талаарх мэдээллийг тогтмол бус, хааяа тохиолдлоор цуглуулдаг бөгөөд мэдээлэл цуглуулахдаа системгүй, эмх замбараагүй арга барил хэрэглэдэг. Цуглуулсан мэдээлэлд хангалттай дүн шинжилгээ хийдэггүй, эсхүл өнгөц, энгийн түвшинд дүн шинжилгээ хийдэг. Улмаар иргэдийн ойлголтын өөрчлөлтийн чиг хандлагыг тодорхойлох оролдлого хийдэггүй.

Баримтжуулалт:

Гээцоо эгч

АЛБАН ХААГЧДЫН ОЙЛГОЛТ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь албан хаагчдын ойлголтоос ихээхэн хамаардаг. Албан хаагчдын ойлголт нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, ажилтнуудын сэтгэл ханамж, мэргэшлийн түвшинд чухал ач холбогдолтой.

Асуулт-97

Байгууллага албан хаагчдын сэтгэл ханамж, байгууллагад үнэнч байдал, ажлын байрны уур амьсгал, манлайлал, хөгжлийн боломж зэрэг ойлголтыг системтэйгээр, тогтмол хугацаанд цуглуулж, цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ойлголтыг тодорхойлдог.

Хариулт:

Байгууллага албан хаагчдын ойлголтыг тогтмол бус, тохиолдлын шинжтэйгээр цуглуулах нь ажиглагддаг бөгөөд үүний нэгэн жишээ нь жилийн эцэст санал асуулга авах явдал юм. Цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийгддэг боловч, уг дүн шинжилгээ нь хангалттай гүнзгий, системтэй бус байх төлөвтэй байна. Ойлголтыг тодорхойлох оролдлого хааяа ажиглагдах хэдий ч, эдгээр нь тогтмол бус бөгөөд хариу арга хэмжээ авах нь ховор тохиолдолд хамаардаг.

Баримтжуулалт:

Золоо

Асуулт-98

Албан хаагчдын ойлголтын үр дүнг зөвхөн хэмжилт, үнэлгээнд ашиглаад зогсохгүй, хүний нөөцийн бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааг сайжруулах, ажилтнуудын сэтгэл ханамж, идэвх зүтгэлийг дээшлүүлэх, байгууллагын соёлыг хөгжүүлэх, өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд идэвхтэй ашигладаг.

Хариулт:

Албан хаагчдын ойлголтын үр дүнг хэмжих анхны оролдлогууд хэрэгжиж эхэлж байгаа хэдий ч судалгаа, санал асуулга зэрэг арга хэрэгслээр мэдээлэл цуглуулах ажил хийгдэж байгаа боловч уг үр дүнд дүн шинжилгээ хийж, практикт үр дүнтэй ашиглах нь хангалтгүй байна. Түүнчлэн хүний нөөцийн бодлого, хөтөлбөрт тодорхой өөрчлөлтүүд орж эхэлж байгаа боловч эдгээр нь системтэй, төлөвлөгөөтэй бус, харин хариу арга хэмжээ авах чиглэлтэй байгаа нь харагдаж байна.

Баримтжуулалт:

Золоо

Асуулт-99

Албан хаагчдын ойлголтыг хэмжихдээ сэтгэл ханамж, удирдлага, манлайлал, хөгжлийн боломж, ажлын байрны орчин, цалин хөлс, урамшуулал, ажлын ачаалал, ажил амралтын тэнцвэр зэрэг ажилтнуудын сэтгэл ханамж, идэвх зүтгэлд нөлөөлдөг гол хүчин зүйлсийг харгалзан үзэж, эдгээр хүчин зүйлээр ойлголтын түвшинг тогтмол үнэлдэг.

Хариулт:

Байгууллага нь албан хаагчдын ойлголтыг хэмжих чиглэлд анхны оролдлогуудыг санаачилж байгаа бөгөөд албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааг тодорхой бус хугацаанд, хааяа нэг удаа зохион байгуулдаг боловч судалгааны үр дүнг бүрэн дүүрэн ашигладаггүй байна. Хэмжилтийг сэтгэл ханамж, удирдлага, манлайлал, хөгжлийн боломж, ажлын байрны орчин, цалин хөлс, урамшуулал, ажлын ачаалал, ажил амралтын тэнцвэр зэрэг хүчин зүйлсийг хамруулан гүйцэтгэдэг хэдий ч гүнзгийрүүлсэн дүн шинжилгээ хийгдэхгүй байна. Илэрсэн асуудлуудыг залруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх хүчин чармайлт гаргадаг ч үр дүн нь хангалтгүй байгаа нь ажиглагдаж байна.

Баримтжуулалт:

Золоо

Асуулт-100

Албан хаагчдын ойлголтын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ажилтнуудын ойлголтын өөрчлөлтийн чиг хандлагыг тодорхойлж, эерэг болон сөрөг чиг хандлагын шалтгааныг судалдаг.

Хариулт:

Албан хаагчдын ойлголтын талаарх мэдээллийг цуглуулах анхны арга зүй бүрэлдэн тогтож эхэлж байгаа хэдий ч мэдээлэл цуглуулалт хангалттай тогтмол, системтэй бус байгаагаас дүн шинжилгээний түвшин өнгөц, тохиолдлын шинжтэй хязгаарлагдаж байна. Улмаар чиг хандлагыг тодорхойлох, уг асуудлын шалтгааныг гүнзгийрүүлэн судлах хүчин чармайлт хангалтгүй байна.

Баримтжуулалт:

Золоо

ХУВИЙН ХЭВШИЛ БА ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ОРОЛЦОГЧДЫН ОЙЛГОЛТ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь хувийн хэвшил ба төрийн захиргааны оролцогч талуудын ойлголтоос ихээхэн хамааралтай байдаг. Бизнес ба төрийн захиргааны оролцогч талуудын ойлголт нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, нийгмийн сайн сайхан байдалд чухал ач холбогдолтой.

Асуулт-101

Байгууллага бизнес эрхлэгчид, хувийн хэвшил болон бусад захиргааны байгууллагуудын байгууллагын үйл ажиллагаа, хамтын ажиллагааны талаарх сэтгэл ханамж, хамтын ажиллагааны үр дүн, үйлчилгээний чанар, мэдээллийн хүртээмж, харилцааны үр нөлөө зэрэг ойлголтыг системтэйгээр, тогтмол хугацаанд цуглуулж, цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ойлголтыг тодорхойлдог.

Хариулт:

Байгууллага нь бизнес болон захиргааны оролцогч талуудын санал бодлыг системтэйгээр цуглуулж, цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийн, тэдгээр санал бодлыг тодорхойлдог. Харин, энэ нь бүх оролцогч талуудыг бүрэн хамруулахгүй байх

магадлалтай бөгөөд цуглуулсан мэдээллийг байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад бүрэн дүүрэн ашиглаж чаддаггүй.

Баримтжуулалт:

Цэнгэл эгч

Асуулт-102

Байгууллага бизнес ба захиргааны оролцогчдын ойлголтыг хэмжихдээ хамтын ажиллагааны үр дүн, түншлэлийн үнэ цэнэ, харилцааны чанар, үйлчилгээний хурд, үр ашиг, ил тод байдал, хариуцлагатай байдал зэрэг гол үзүүлэлтүүдийг харгалзан тогтмол үнэлж, тэдний ойлголтыг сайтар тодорхойлдог.

Хариулт:

Байгууллагаас бизнес болон захиргааны оролцогч талуудын ойлголтыг хэмжих анхны алхмуудыг авч эхэлж байгаа боловч санал асуулга болон албан бус санал хүсэлт цуглуулах зэрэг үйл ажиллагаа нь системгүй, тогтмол бус явагдаж, гол үзүүлэлтүүдийг бүрэн хэмжихгүй эсвэл хязгаарлагдмал хүрээнд авч үздэг байна.

Баримтжуулалт:

Гээцоо эгч

Асуулт-103

Бизнес нь захиргааны оролцогчдын ойлголтын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ойлголтын өөрчлөлтийн чиг хандлагыг тодорхойлон, эерэг болон сөрөг чиг хандлагын шалтгааныг судалдаг.

Хариулт:

Бизнес нь захиргааны оролцогчдын ойлголтын талаарх мэдээллийг санамсаргүй байдлаар цуглуулж эхэлдэг бөгөөд мэдээлэлд дүн шинжилгээ хийх оролдлого гардаг хэдий ч эдгээр нь системгүй, гүнзгий бус байдлаар хэрэгждэг. Ойлголтын өөрчлөлтийн чиг хандлагыг тодорхойлох, шалтгааныг судлах үйл явц хараахан эхлээгүй байна.

Баримтжуулалт:

Одбаяр

Асуулт-104

Байгууллага нь бизнес ба захиргааны оролцогчдын ойлголтын үр дүнг зөвхөн хэмжилт, үнэлгээнд ашиглаад зогсохгүй, харин хамтын ажиллагааг хөгжүүлэх, түншлэлийг бэхжүүлэх, үйлчилгээг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, инноваци нэвтрүүлэхэд идэвхтэй ашигладаг.

Хариулт:

Байгууллага нь оролцогч талуудын ойлголтын ач холбогдлыг ухамсарлан ойлгож эхэлж байгаа боловч санал хүсэлтийг цуглуулах үйл ажиллагаа нь тогтмол бус, системгүй хэлбэртэй хэрэгжиж, цуглуулсан мэдээллийг үнэлгээнд ашигладаг хэдий ч хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, үйлчилгээг сайжруулах, инноваци нэвтрүүлэхэд хангалттай хэмжээнд ашигладаггүй байна.

Баримтжуулалт:

Гээцоо эгч

НИЙГМИЙН ОЙЛГОЛТ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь нийгмийн ойлголтын үр дүнгээс хамаардаг. Нийгмийн ойлголт нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, нийгмийн сайн сайхан байдалд чухал ач холбогдолтой.

Асуулт-105

Байгууллага нь байгууллагын нийгмийн үйл ажиллагаа, нийгэмд үзүүлж буй нөлөөлөл, байгууллагын нэр хүнд, нийгмийн итгэл, хариуцлагатай байдал, үнэ цэнэтэй байдал, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах байдал зэрэг ойлголтыг системтэйгээр, тогтмол хугацаанд цуглуулж, цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ойлголтыг тодорхойлдог.

Хариулт:

Байгууллага нь нийгмийн ойлголтын үр дүнг тогтмол хугацаанд цуглуулах, анхан шатны дүн шинжилгээ хийх процессуудыг бүрдүүлж эхэлсэн боловч тодорхой аргачлал, судалгааны арга зүйг нэвтрүүлэн ашиглаж байгаа нь хараахан төгс бус бөгөөд сайжруулах шаардлагатай хэвээр байна. Түүнчлэн цуглуулсан мэдээлэлд үндэслэн нийгмийн ойлголтыг тодорхойлох анхны оролдлогуудыг гаргаж, дүн шинжилгээний үр дүнг байгууллагын үйл ажиллагаанд тусгах эхний алхмуудыг хэрэгжүүлж байна.

Баримтжуулалт:

НХХ

Асуулт-106

Байгууллага нийгмийн ойлголтыг хэмжихдээ байгууллагын нэр хүнд, нийгмийн итгэл, хариуцлагатай байдал, ил тод байдал, ёс зүй, шударга байдал, нийгмийн сайн сайхан байдалд хувь нэмэр оруулах байдал, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах байдал зэрэг гол үзүүлэлтүүдийг харгалзан, эдгээр үзүүлэлтээр ойлголтын түвшинг тогтмол үнэлдэг.

Хариулт:

Байгууллага нь нийгмийн ойлголтыг тогтмол хэмжих зорилготой бөгөөд нэр хүнд, нийгмийн итгэл, хариуцлагатай байдал зэрэг гол үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих аргачлал боловсруулах ажлыг эхлүүлж байна. Гэсэн хэдий ч эдгээр хэмжилтүүд нь хангалттай бүрэн дүүрэн бус, тогтмол бус байж болно. Мөн нийгмийн харилцааг системтэйгээр удирдан зохион байгуулах эхлэл тавигдаж байна.

Баримтжуулалт:

НХХ

Асуулт-107

Байгууллага цуглуулсан нийгмийн ойлголтын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, нийгмийн ойлголтын өөрчлөлтийн чиг хандлагыг тодорхойлж, эерэг болон сөрөг чиг хандлагын шалтгааныг судалдаг.

Хариулт:

Байгууллага нийгмийн ойлголтын талаарх мэдээллийг тогтмол бус, хааяа цуглуулах хандлагатай байгаа нь ажиглагдаж байна. Мэдээлэл цуглуулахдаа тодорхой аргачлал, системгүй байна. Ийнхүү цуглуулсан мэдээлэлд энгийн дүн шинжилгээ хийж, нийгмийн ойлголтын өөрчлөлтийг ерөнхий байдлаар тодорхойлох оролдлого хийдэг хэдий ч эерэг болон сөрөг чиг хандлагын шалтгааныг гүнзгийрүүлэн судлах ажил хийгдэхгүй байна.

Баримтжуулалт:

НХХ

Асуулт-108

Байгууллага нийгмийн ойлголтын үр дүнг зөвхөн хэмжилт, үнэлгээнд ашиглаад зогсохгүй, харин нийгмийн хариуцлагын бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааг сайжруулах, нийгмийн сайн сайхан байдалд хувь нэмрээ оруулах үйл ажиллагааг идэвхжүүлж, байгууллагын нийгмийн хариуцлагын соёлыг хөгжүүлэхэд идэвхтэй ашигладаг.

Хариулт:

Байгууллага нийгмийн ойлголтын үр дүнг тогтмол хэмжин үнэлж, нийгмийн хариуцлагын бодлого, хөтөлбөрөө боловсронгуй болгоход ашиглаж эхэлж байгаа боловч сайжруулалт нь системтэй бус, хааяа тохиолдлын шинжтэй байх хандлагатай байна. Нийгмийн хариуцлагын соёл аажмаар төлөвшин хөгжиж байна.

Баримтжуулалт:

НХХ

ТҮНШҮҮД, ХАРИЛЦАГЧ, НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ОЙЛГОЛТ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь түншүүд, харилцагч, нийлүүлэгчдийн ойлголтын үр дүнгээс хамаардаг. Түншүүд, харилцагч, нийлүүлэгчдийн ойлголт нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, нийгмийн сайн сайхан байдалд чухал ач холбогдолтой.

Асуулт-109

Байгууллага нь түншүүд болон нийлүүлэгчдийн байгууллагатай харилцах харилцаа, хамтын ажиллагааны талаарх сэтгэл ханамж, харилцааны үр дүн, хамтын ажиллагааны үнэ цэнэ, харилцааны чанар, шударга ёс, ил тод байдал зэрэг ойлголтыг системтэйгээр, тогтмол хугацаанд цуглуулж, цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ойлголтын үр дүнг тодорхойлдог.

Хариулт:

Байгууллага нь түншүүд болон нийлүүлэгчдийн ойлголтыг цуглуулах хэрэгцээг хүлээн зөвшөөрдөг боловч системтэй арга барил хараахан бүрдээгүй байна. Ойлголтыг цуглуулахдаа зарим тохиолдолд санал асуулга, эсвэл албан бус уулзалтыг ашигладаг боловч цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх нь хязгаарлагдмал, үр дүнг тодорхойлох нь хангалтгүй гэж тодорхойлж болно.

Баримтжуулалт:

Гээцоо эгч

Асуулт-110

Байгууллага түншүүд ба нийлүүлэгчдийн ойлголтыг хэмжихдээ харилцааны үнэ цэнэ, түншлэлийн үр ашиг, үйл ажиллагааны чанар, хурд, харилцааны шударга ёс, ил тод байдал, харилцан ашигтай байдал зэрэг гол үзүүлэлтүүдийг харгалзан үзэж, эдгээр үзүүлэлтээр ойлголтын түвшинг тогтмол үнэлдэг.

Хариулт:

Байгууллага нь түншүүд болон нийлүүлэгчдийн ойлголтыг хэмжих суурь ойлголттой болж эхэлж байгаа боловч судалгаа, санал асуулга тогтмол бус, системгүй хэлбэрээр явагддаг. Гол үзүүлэлтүүдийг бүрэн бус байдлаар харгалзан үздэг бөгөөд ойлголтын түвшинг хааяа үнэлдэг.

Баримтжуулалт:

Одбаяр

Асуулт-111

Байгууллага түншүүд ба нийлүүлэгчдийн ойлголтыг хэмжихдээ харилцааны үнэ цэнэ, түншлэлийн үр ашиг, үйл ажиллагааны чанар, хурд, харилцааны шударга ёс, ил тод байдал, харилцан ашигтай байдал зэрэг гол үзүүлэлтүүдийг харгалзан үзэж, эдгээр үзүүлэлтээр ойлголтын түвшинг тогтмол үнэлдэг.

Хариулт:

Байгууллага нь түншүүд болон нийлүүлэгчдийн ойлголтыг хэмжих хэрэгцээг ухамсарлаж эхэлсэн хэдий ч хэмжилтийг тогтолцоогүй, системгүйгээр хэрэгжүүлдэг бөгөөд санал асуулгыг хааяа нэг удаа, тогтмол бусаар авч, гол үзүүлэлтүүдийг бүрэн дүүрэн харгалздаггүй нь тогтоогдсон.

Баримтжуулалт:

Одбаяр

Асуулт-112

Түншүүд ба нийлүүлэгчдийн ойлголтын үр дүнг зөвхөн хэмжилт, үнэлгээнд ашиглаад зогсохгүй, харин түншлэл, нийлүүлэлтийн харилцааг хөгжүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхэд идэвхтэй ашигладаг.

Хариулт:

Түншүүд болон нийлүүлэгчдийн ойлголтын ач холбогдлыг ойлгох хандлага ажиглагдаж байгаа хэдий ч санал хүсэлтийг цуглуулах үйл ажиллагаа нь тогтмол, системтэй хэлбэрт шилжээгүй байна. Мөн түүнчлэн цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, цаашид ашиглах үйл явц хангалтгүй эсхүл хязгаарлагдмал байна.

Баримтжуулалт:

Одбаяр

СТРАТЕГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь стратегийн болон үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнгээс хамаардаг. Стратегийн болон үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүн нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, нийгмийн сайн сайхан байдалд чухал ач холбогдолтой.

Асуулт-113

Стратегийн болон үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг үнэлэхдээ байгууллагын стратеги, зорилго, алсын хараатай бүрэн уялдуулж, нийтийн үнэ цэнийг бий болгох, иргэдэд үйлчлэх зорилгод хүрэхэд чиглэсэн үр дүнг тодорхойлдог.

Хариулт:

Байгууллагын стратеги, зорилго, алсын харааг тодорхойлох, гүйцэтгэлийн үнэлгээтэй уялдуулах чиглэлээр тодорхой үйл ажиллагаа явагдаж байгаа бөгөөд гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх тогтолцоог бүрдүүлэн хэрэгжүүлж эхэлсэн байна. Түүнчлэн нийтийн үнэ цэнэ бий болгох, иргэдэд үйлчлэх зорилгыг гүйцэтгэлийн үнэлгээнд тусгах зорилготой байна.

Баримтжуулалт:

Оюунбаатар

Асуулт-114

Стратегийн болон үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг хэмжихдээ тодорхой, хэмжигдэхүйц, хүрэхүйц, бодитой, цаг хугацаатай шалгуур үзүүлэлтүүд (KPI) ашиглаж, эдгээр үзүүлэлтээр зорилтот түвшинд хүрсэн амжилтыг үнэлдэг.

Хариулт:

Гүйцэтгэлийг хэмжих анхны оролдлогууд хийгдэж, зарим үндсэн KPI үзүүлэлтүүдийг тодорхойлсон хэдий ч эдгээр нь байгууллагын стратегийн зорилготой бүрэн дүүрэн уялдаа холбоогүй, хэмжилтийн тогтвортой байдал хангалтгүй байна. KPI үзүүлэлтийг ашиглах талаарх ойлголт аажмаар нэмэгдэж байгаа боловч практик хэрэглээ хангалттай түвшинд хүрээгүй байна. Мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа явагдаж байгаа хэдий ч цуглуулсан мэдээллийг үр дүнтэй ашиглах боломж хангалтгүй байна. Үр дүнгийн тайлагнал хангалтгүй түвшинд байгаа нь ажиглагдаж байна.

Баримтжуулалт:

Цэнгэл эгч

Асуулт-115

Стратегийн болон үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг үнэлэхдээ цаг хугацааны явцад ахиц дэвшил, эерэг чиг хандлага, тасралтгүй сайжруулалтын үйл явцыг харгалзан үздэг.

Хариулт:

Гүйцэтгэлийн үр дүнг хэмжих, үнэлэх тодорхой процессууд бүрдэж эхэлсэн бөгөөд үр дүнг тогтмол хянах, цаг хугацааны явцад гарах ахиц дэвшил, эерэг хандлагыг тодорхойлох зорилготой оролдлогууд хийгдэж байна. Сайжруулалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх эхлэл тавигдаж байгаа хэдий ч эдгээр нь системтэй, бүрэн хамрагдахуйц бус байна.

Баримтжуулалт:

Цэнгэл эгч

Асуулт-116

Стратегийн болон үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг үнэлэхдээ салбарын дундаж үзүүлэлт, тэргүүний байгууллагуудын жишиг үзүүлэлт, олон улсын жишиг зэрэг харьцуулсан болон жишиг үзүүлэлтүүдтэй харьцуулж, байгууллагын гүйцэтгэлийг бодитойгоор тодорхойлдог.

Хариулт:

Байгууллага нь салбарын дундаж үзүүлэлтийн талаар мэдлэгтэй боловч үнэлгээний үйл ажиллагаандаа системтэйгээр ашигладаггүй бөгөөд харьцуулсан үзүүлэлтийг зарим тохиолдолд ашиглах боломжтой хэдий ч эдгээр нь тогтмол бус, харин хаа нэг тохиолдолд хэрэглэгддэг байна. Мөн тэргүүний байгууллагуудын жишиг үзүүлэлт болон олон улсын жишиг үзүүлэлтийн талаарх мэдээлэл хангалтгүй байдаг.

Баримтжуулалт:

Цэнгэл эгч

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХҮЛЭЭЛТ БОЛОН ТЭДНИЙ ХУВЬ НЭМЭР

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь оролцогч талуудын хүлээлтийг хангах болон тэдний хувь нэмрээс хамаардаг. Оролцогч талуудын хүлээлт, тэдний хувь нэмэр нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, нийгмийн сайн сайхан байдалд чухал ач холбогдолтой.

Асуулт-117

Гол оролцогч талуудын байгууллагаас хүлээлтийг тодорхойлж, эдгээр хүлээлтийг хэрхэн хангаж байгаа, ямар үр дүнд хүрснийг тодорхой шалгуур үзүүлэлтээр хэмждэг.

Хариулт:

Байгууллага нь оролцогч талуудын хүрээг ойлгож эхэлж байгаа боловч тэдгээрийн хүлээлтийг системтэйгээр тодорхойлох, хангаж ажиллах үйл явц хангалтгүй байна. Оролцогч талуудын хүлээлтийг тодорхойлохдоо таамаглалд үндэслэх эсвэл ганц удаагийн судалгаа хийх зэрэг арга хэмжээ авдаг боловч хүлээлтийг хангах арга хэмжээ нь төлөвлөгөөгүй, хариу үйлдэл үзүүлэх хэлбэрт давамгайлдаг.

Баримтжуулалт:

Одбаяр

Асуулт-118

Байгууллага гол оролцогч талууд байгууллагын үйл ажиллагаанд оруулж буй хувь нэмрийг үнэлж, эдгээр хувь нэмэр нь байгууллагын амжилт, гүйцэтгэлд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлдог.

Хариулт:

Байгууллага нь оролцогч талуудын хувь нэмрийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрөх эхний шатанд байгаа хэдий ч, оролцогч талуудын хувь нэмрийг үнэлэх болон ойлгох аргачлал нь хангалттай бус, тогтолцоогүй хэвээр байна. Оролцогч талуудын хувь нэмрийг байгууллагын амжилттай уялдуулах анхан шатны оролдлогууд хийгдэж байгаа боловч эдгээр нь хангалттай түвшинд хүрээгүй байна.

Баримтжуулалт:

Гээцоо эгч

Асуулт-119

Байгууллага оролцогч талуудын хүлээлт хангасан болон хувь нэмэр оруулсан үр дүнг үнэлэхдээ салбарын дундаж, тэргүүний байгууллагуудын болон олон улсын жишиг үзүүлэлтүүдтэй харьцуулан гүйцэтгэлийн түвшинг тодорхойлдог.

Хариулт:

Байгууллага нь оролцогч талуудын хүлээлтийг хангаж, тэдний оруулж буй хувь нэмрийг үнэлэхэд чиглэсэн цэгцтэй тогтолцоог бүрэн төлөвшүүлж чадаагүй байна. Түүнчлэн салбарын дундаж, тэргүүний байгууллагуудын болон олон улсын жишиг үзүүлэлтүүдийг харьцуулан үнэлэх ойлголт дутмаг эсхүл хангалтгүй байгаа нь ажиглагдаж байна. Эдгээр хүчин зүйлсийн улмаас оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа нь системгүй, санамсаргүй хэлбэртэй явагдаж байна.

Баримтжуулалт:

Цэнгэл эгч

Асуулт-120

Байгууллага оролцогч талуудын хүлээлт хангасан болон хувь нэмэр оруулсан үр дүнгийн хэмжилтийн үр дүнг ашиглан тасралтгүй сайжруулалт, хөгжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэн, оролцогч талуудын хүлээлтийг хангах, хувь нэмрийг нэмэгдүүлэх, харилцааг бэхжүүлэх арга замыг тасралтгүй эрэлхийлдэг.

Хариулт:

Байгууллага нь оролцогч талуудын оршин буйг хүлээн зөвшөөрч, тэдгээрийн хүлээлтэд тодорхой хэмжээгээр анхаарал хандуулах хандлага ажиглагдаж байгаа боловч оролцогч талуудын хүлээлтийг ойлгох оролдлого нь системгүй, хаа нэг тохиолдох байдлаар хэрэгждэг бөгөөд сайжруулах оролдлогууд мөн л хааяа ажиглагддаг.

Баримтжуулалт:

Одбаяр

ИРЭЭДҮЙГ УРЬДЧИЛАН ТААМАГЛАХ

Тайлбар:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын амжилттай үйл ажиллагаа нь ирээдүйг урьдчилан таамаглах чадвараас хамаардаг. Ирээдүйг урьдчилан таамаглах нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, нийгмийн сайн сайхан байдалд чухал ач холбогдолтой.

Асуулт-121

Байгууллага ирээдүйн гүйцэтгэлийг урьдчилан таамаглахдаа бодит өгөгдөл, тоон үзүүлэлт, судалгаа шинжилгээнд үндэслэсэн, үнэн зөв мэдээлэлд тулгуурласан аргачлалыг ашигладаг.

Хариулт:

Байгууллага ирээдүйг урьдчилан таамаглахын чухлыг ухамсарлаж эхэлж байна. Зарим тохиолдолд өнгөрсөн үеийн өгөгдөлд үндэслэн энгийн таамаглал дэвшүүлэх оролдлого гаргадаг. Гэсэн хэдий ч бодит өгөгдөл цуглуулах, тоон үзүүлэлт хэмжих, судалгаа шинжилгээ хийх зэрэг үйл ажиллагаа нь системгүй, хангалттай бус түвшинд хэрэгждэг. Хэрэглэгдэж буй аргачлал нь тодорхойгүй, үнэн зөв мэдээлэлд үндэслээгүй байх магадлалтай.

Баримтжуулалт:

Одбаяр

Асуулт-122

Байгууллага ирээдүйн гүйцэтгэлийг урьдчилан таамаглахдаа байгууллагын стратеги, зорилго, алсын хараатай уялдаа холбоотой, нийтийн үнэ цэнийг бий болгох, иргэдэд үйлчлэх гол зорилгод бүрэн нийцүүлэн хийдэг.

Хариулт:

Ирээдүйн гүйцэтгэлийг урьдчилан таамаглах ажиллагааны анхны оролдлогууд хийгдэж байгаа нь ажиглагдаж байна. Стратеги, зорилго, алсын харааг тодорхойлох эхлэл тавигдаж, урьдчилсан таамаглалд анхаарал хандуулж эхэлсэн хэдий ч, эдгээр

таамаглалууд нь хангалттай хэмжээнд боловсронгуй бус байгаагийн зэрэгцээ нийтийн үнэ цэнэ болон иргэдэд үйлчлэх зорилготой уялдаа холбоо хангалтгүй түвшинд байна.

Баримтжуулалт:

Одбаяр

Асуулт-123

Байгууллага ирээдүйн гүйцэтгэлийг урьдчилан таамаглах үйл явцыг тасралтгүй сайжруулалт, суралцахуйн үйл явц болгон хөгжүүлж, таамаглалын чанарыг байнга дээшлүүлдэг.

Хариулт:

Байгууллага ирээдүйг урьдчилан таамаглах шаардлагыг ухамсарлан ойлгож эхэлж байгаа боловч урьдчилан таамаглах үйл явц нь зөвхөн суурь төвшинд бүрэлдэн тогтож, хангалттай системтэй хөгжөөгүй, мөн урьдчилсан таамаглал нь голчлон өнгөрсөн үеийн чиг хандлагад тулгуурлан энгийн аргачлалыг ашигладаг байна.

Баримтжуулалт:

Одбаяр

Асуулт-124

Байгууллага ирээдүйн гүйцэтгэлийг урьдчилан таамаглах үйл явцад ажилтнууд болон гол оролцогч талуудыг оролцуулж, тэдний мэдлэг, туршлага, санал бодлыг харгалзан үздэг.

Хариулт:

Байгууллага нь ирээдүйн гүйцэтгэлийг урьдчилан таамаглах шаардлагатай гэдгийг ухамсарлан ойлгож эхэлж байгаа боловч энэхүү үйл ажиллагаа нь хязгаарлагдмал хүрээнд явагддаг. Урьдчилан таамаглах үйл явцад ажилтнуудыг болон гол оролцогч талуудыг хангалттай оролцуулдаггүйгээс гадна тэдний санал бодлыг бүрэн дүүрэн харгалзан үздэггүй байна.

Баримтжуулалт:

Одбаяр

БАТАЛГААЖУУЛСАН
ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

ТАЙЛАГНАСАН
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Б.ОДБАЯР